**ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН**
**2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

| № | Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | 2025 оны зорилтот түвшин | Хэрэгжилт | Өөрийн үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго: Эх, хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн шинэ дэвшилтэт технологийг эрчимтэй нэвтрүүлж, тохь тухтай орчинд чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээг үзүүлнэ.** | | | | | | | |
| **Зорилт 1.1 Эрүүл мэндийн сайдын тусгай захиалгат арга хэмжээ** | | | | | | | |
| 1.1.1 | БСТ-1.1.4.1. Хүүхдийн зүрхний нээлттэй мэс заслыг эхлүүлж, зүрхний хөх гажгийн мэс заслыг хийнэ. | 2,9 тэрбум.төг (НҮБ ХАС) | Заалт бүхий тохиолдолд зүрхний нээлттэй мэс засал хийсэн тоо | 5 | 10 | • ЭХЭМҮТ-ийн захирлын тушаалаар "Нярайн зүрхний мэс заслын баг"-ийн томилж, зүрхний мэс заслын эмч, хүүхдийн зүрхний эмч, мэдээгүйжүүлгийн эмч, перфузиологич эмч, эрчимт эмчилгээний эмч, хагалгааны сувилагч, мэдээгүйжүүлгийн сувилагч, эрчимт эмчилгээний сувилагч гэсэн 8 хүний бүрэлдэхүүнтэй 3 баг байгуулагдсан.<br>• Өмнөд Солонгос улсын Самсунг эмнэлгийн Зүрхний төвд 2 багийн 16 эмч, сувилагч нарыг 1-3 сарын сургалтанд,<br>• БНХАУ-ын Шанхай хотын Фудан эмнэлэгт 1 багийн 5 эмч, сувилагчийг 1-6 сарын хугацаатай сургалтанд хамруулсан.<br>• Мөн 3 эмчийг Европийн Холбооны зүрхний мэс заслын жил бүр зохион байгуулагддаг хуралд оролцуулан, Страссбургийн Зүрхний төвд туршлага судлах боломж олгосон.<br>• ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлэг дээр 2025 оны 10 сарын 17-нд нярайн зүрхний нээлттэй мэс засал хийх боломжтой 1-р зэрэглэлийн 2 вакум хагалгааны өрөөний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | засвар, тохижилтийн ажил, мөн нярайн зүрхний нээлттэй мэс заслын дараах эрчимт эмчилгээний хэсгийн засварын ажил дуусч нээлтийн үйл ажиллагаа болсон. Уг засвар тохижилтын ажил нь Люксембургийн Их Гүнт улс, НҮБ ХАС-ын санхүүгийн болон техникийн дэмжлэгтэй нийт **1.2 тэрбум төгрөгийн** санхүүжилтээр хийгдсэн байна.<br>• Мөн зүрхний нээлттэй мэс засал хийх 92 нэр төрлийн 396 ширхэг 474,483 долларын үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж, мэс заслын багаж хэрэгслийг хүлээн авсан.<br>• ЭХЭМҮТ, УГТЭ, Люксембургын хүүхдийн зүрхний мэс заслын эмч нартай хамтарч зүрхний төрөлхийн гажигтай 92 хүүхэд үзэж, зөвөлгөө өгсөн. УГТЭ-д нийт **20 хүүхдэд зүрхний нээлттэй мэс заслыг амжилттай хийсэн.** Үүнээс 3 дутуу нярай. **ЭХЭМҮТ-д 2 хүүхдэд хөнгөвчлөх мэс засал хийсэн.**<br>• 2025.06.14-20 өдрүүдэд Люксембург улсаас зүрхний эмч нарын баг ирсэн. 30 хүүхдэд үзлэг хийсэн. | |
| 1.1.2 | БСТ-1.1.4.6. Дутуу нярайн ретинопатийн үеийн торлог, шилэнцрийн мэс заслын тоог нэмэгдүүлнэ. | - | Амжилттай хийсэн мэс заслын тоо | 5 | 10 | • ДНР-ийн илрүүлэх скрининг үзлэгт **FORUS оношилгооны аппаратыг** хэрэглэж эмчилгээг олон улсын түвшинд, нотолгоонд суурилсан ДНР-ийн оношилгоо эмчилгээ хийгдэж байна. Нийт 302 нярайд нүдний цгийн зураг авсан.<br>• 2025 онд **1950** ДНР-ийн скрининг үзлэг хийгдсэн ба ДНР эмгэг илэрсэн **993** дутуу нярайг хянаж, **71 дутуу нярайд (Laser 12 ба Anti VEGF эмийн эмчилгээ 59) эмчилгээ хийгдсэн.**<br>• **Дүгнэлт:** Нийт **71 нярай** ДНР-ийн 1-р хэлбэр оношилогдож эмгэг судасны ургалтыг зогсоох эмийн эмчилгээ ба | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | торлогийн лазер эмчилгээ хийгдсэн ба **512** нярайд ДНР-ийн 2-р хэлбэр оношилогдож эмийн эмчилгээгүй намжмал байдалд орсон.<br>• **Хийгдсэн мэс заслыг төрлөөр нь авч үзвэл:** Торлогийн мэс засал 2, торлог шилэнцрийн мэс засал 4, лазер эмчилгээ 16, шилэнцрийн мэс засал 6, **нийт 28 мэс засал** хийгдсэн байна. | |
| 1.1.3 | БСТ-1.2.3.1. Ургаас урагт цус юүлэх хам шинжийн үеийн лазер мэс заслын тоог нэмэгдүүлнэ. | - | Заалт бүхий тохиолдолд хийсэн мэс заслын тоо | 5 | 10 | • Ихэр жирэмсний үед ургаас урагт цус юүлэгдэх хамшинжийг /УУЦЮХШ/ лазер мэс заслаар эмчлэх дэвшилтэт технологийг нэвтрүүлж: 2020 онд-1, 2021 онд-3, 2022 онд-5, 2023 онд-2, 2024 онд-4, 2025 онд-3 тохиолдолд, нийт өссөн дүнгээр **18 тохиолдолд лазер мэс засал** хийсэн.<br>• 2025 онд заалт бүхий 3 тохиолдолд ургийн лазер мэс засал, 2 тохиолдолд фетоцид эмчилгээ хийсэн байна.<br>1. 2025.02.01-нд DS: GrII-I 23.5weeks TTTS list, short cervix, pyelonephitis, right hydronephrosis, cervix dysplasia.<br>2. 2025.03.13-нд DS: Gr VI-V 27.0 weeks, MCDA twins, TTTS II stage. 3. Chronic pyelonephritis. Anemia 1st.<br>3. 2025.06.02-нд DS: GrIV-III 20-21 д.х, TTTS III stage. | 100% |
| 1.1.4 | “Эрт илрүүлэг-2” хөтөлбөрийн хүрээнд мэргэжил, арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулж, судалгаа хийнэ | 100,0 сая.төг (Улсын төсөв) | -Сургалтанд хамрагдсан хүний тоо<br>-судалгааны тайлан | 0 | 300 | • Сургуульд суурилсан эрт илрүүлгийн тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд “Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн сурагчдад зүрхний эмгэгийн эрт илрүүлгийг хийх 21 аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт” 2025 оны 03 сарын 24-28-ны хооронд ЭХЭМҮТ-д зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулагдаж, **850 гаруй эмч, мэргэжилтэн** хамрагдсан. | |
| 1.1.5 | Эх ургийн анагаах ухааны мэргэжилтнийг үе шаттайгаар бүсчлэн сургана | - | Сургалтанд хамрагдсан хүний тоо | 3 | 4 | • Эх ургийн анагаах ухаан төрөлжсөн мэргэшлээр эх барих эмэгтэйчүүдийн **7 эмч суралцсанаас** өмнөх элсэлтийн **4 эмч** амжилттай суралцаж төгссөн. Захиалагч байгууллага: ЭХЭМҮТ-2, ЭНЭҮТ-1, Таны төлөө бид эмнэлэг-1.<br>• Одоо 3 эмч үргэлжлүүлэн суралцаж байна. | 100% |
| 1.1.6 | Сургуульд суурилсан эрт илрүүлгийн хэрэгцээг тодорхойлох судалгаа хийх, заавар, аргачлал боловсруулж, мэргэжил аргазүйгээр ханган ажиллах, эрт илрүүлгийн чадамж олгох сургалтыг зохион байгуулна | - | Судалгааны тайлан, Боловсруулсан заавар, аргачлал, Сургалт хамрагдсан эмчийн тоо | 1<br><br>260 | 1<br><br>300 | • ЭМЯ, НЭМГ-тай хамтран нийслэлийн бүх өрхийн эмнэлгийн төлөөлөл, эмч, сувилагч нарт 6 настай хүүхдийн ЗЦБ хийх арга, аргачлал, хиймэл оюун ухаанд суурилсан ЗБ-ийн аппаратыг ашиглах аргачлалаар ЭХЭМҮТ дээр **1 удаагийн** сургалтыг амжилттай зохион байгуулсан.<br>• Сургалтанд нийслэлийн өрхийн эмнэлгүүдээс нийт **300 гаруй эмч, сувилагч** хамрагдсан.<br>• Эрүүл мэндийн болон Боловсролын сайдын 2024 оны А80/А384 тоот тушаалын дагуу 2024 онд ЕБС-ийн 1-р ангид элссэн суралцаж буй 33918 хүүхдийг (хамрагдалтын хувь 83.2%) Улаанбаатарт, 36476 хүүхдийг (хамрагдалтын хувь 93.7%) аймаг, орон нутагт хамруулсан.<br>• Илрүүлгийн үр дүнд нийт хамрагдсан хүүхдийн 21%-д зүрхний цахилгаан бичлэгийн өөрчлөлт илрэн эдгээрээс зүрхний бүтцийн өөрчлөлт **450 хүүхэд** нь оношлогдсон байна.<br>• Ухаалаг зүрхний цахилгаан бичлэгийн аппаратыг нэвтрүүлсэн. Анхан шатны **558 эрүүл мэндийн байгууллагыг** “Эрүүл монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд уг аппаратаар хангасан ба аппаратын тусламжтайгаар зүрхний цахилгаан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичлэгийг хэвлэхгүйгээр цахим хэлбэрээр ЭМС-ийн тушаалаар батлагдсан хүүхдийн зүрхний 20 эксперт эмч нарт илгээж өвчтөнийг цаг алдалгүй оношлох боломж бүрдсэн байна.<br>• ЗЦБ-ын эрт илрүүлгийн гарааны сургалтыг онол, дадлага хослуулан, бүр өрх, сумын эмч нарыг хамруулан зохион байгуулж, гарын авлага боловсруулсан.<br>• Эрт илрүүлгийн үйл ажиллагааг цахим платформоор ЭМЯ нэгтгэн авч үр дүнг тооцсон.<br>• Эрт илрүүлгээр өөрчлөлт илэрсэн тохиолдолд, 21 аймаг, 9 дүүрэгт 6 эксперт эмч нар ажиллан орон нутагт нь Зүрхний хэт авиан шинжилгээ хийж, зүрхний эмгэгийн оношийг тодруулсан.<br>• Зүрхний гажиг, эмгэг илэрсэн тохиолдол бүрийг ЭХЭМҮТ, УГТЭ-т дуудан ирүүлж лавлагаа шатлалын тусламж үзүүлэн зүрхний мэс засал, Зүрхний судсан дотуурх мэс засл, эмийн эмчилгээнд хамруулан хяналт хийж байна.<br>• Мөн тус ажлын хүрээнд ЭМЯ-ны даалгавраар НҮБ ХС-ын дэмжлэгтэй 21 аймаг, 9 дүүргийн нийт 30 эмчийг ЭХЭМҮТ дээр 2025 оны 4 сард 14 хоногийн вакумжуулсан зүрхний хэт авиан шинжилгээний чадавхи олгох онол, дадлага хосолсон сургалтанд хамруулсан.<br>• Экперт эмч нар орон нутаг, дүүрэгт ажиллахдаа дээрх сургалтанд хамрагдсан 30 эмчийг ажлын байран дээр дахин дадлагажуулсан нь аймаг, дүүрэгт хүүхдийн зүрхний эмгэгийн оношилгоог хийх тогтолцоог бүрдүүлсэн чухал ажил болсон байна.<br>• 2 гарын авлага, шинжилгээ аргачлал боловсруулсан. Төвөөс 3 эмч оролцсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1. **“Сургуульд суурилсан эрт илрүүлгээр хүүхдийн хоолой залгиурын эмгэгийг эрт илрүүлэх үзлэгийн гарын авлага”**<br>2. **“Сургуульд суурилсан эрт илрүүлгээр хүүхдийн сонсгол шалгах шинжилгээг хийх гарын авлага”**<br>• “Эрүүл-Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2025.04.26-27 өдрүүдэд Дундговь аймагт эмч нар очиж ажиллан 300 гаруй хүүхдэд үзлэг хийж, зөвлөгөө өгсөн.<br>• Үзлэг хийгдсэн хүүхдүүдээс 25 хүүхдэд чих, хамар хоолойн мэс заслын заалтыг орон нутагт нь гарган шийдвэрлэсэн.<br>• 5 хүүхдийн чихнээс гадны биет авсан.<br>• Үзлэг хийгдсэн нийт хүүхдийн 40% хоолой залгиурын архаг үрэвсэлтэй байснаас 90% нь шүдний өвчлөлттэй хавсарсан байв. | |
| 1.1.7 | 12,15 настай хүүхдүүдийн дунд зонхилон тохиолдох өвчлөлийг судалж, эрт илрүүлгийн хэрэгцээг тодорхойлно | - | Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо, судалгааны тайлан | -<br><br>- | 150<br><br>1 | • Төрөлжсөн мэргэшлийн эмч нарын (чих, хамар хоолой, зүрх, мэдрэл, хоол боловсруулах, дотоод шүүрэл) хамтарсан сургуульд суурилсан **үзлэг хийсэн тоо = 2**<br>• Үзлэг оношилгоонд DANGER, Raecho маркийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, Mindray, Vinno маркийн зөөврийн зүрхний ЭХО аппарат ашиглав.<br>• БЗД-ийн Ерөнхий боловсролын 44, БГД-ийн “Сэтгэмж” сургуулийн 7, 10 дугаар ангийн нийт **141 хүүхэд** хамрагдлаа. **Өөрчлөлт илэрсэн - 9**<br>1. Тосгуур хоорондын таславчийн цоорхойн гажигтай 1 /0,7%/<br>2. Хоёр хавтаст хавхлагын хөнгөн зэргийн дутуу хаагдалтай 6 /4,2%/<br>3. ЗТГ-Гол судасны хөнгөн зэргийн нарийсал 1 /0,7 %/ , | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 4. Гол судасны хавхлагын дутуу хаагдалттай 1 /0.7 %/ тус тус илэрсэн.<br>• Илэрсэн нийт 9 хүүхдийг зүрхний эмчийн хяналтанд авсан.<br>• **Чих, хамар хоолойн үзлэг:** Нийт 15 настай **83 сурагч** үзлэгт хамрагдсанаас:<br>1. Эрүүл 24 хүүхэд (29%)<br>2. Гүйлсэн булчирхайн архаг үрэвсэлтэй 29 хүүхэд (35%)<br>3. Хамар, хамар дайврын үрэвсэлтэй 18 хүүхэд (21,6%)<br>4. Шүд каристай 10 (2,4%)<br>5. Нийт 12 настай 79 хүүхэд үзлэгт хамрагдсанаас:<br>1. Эрүүл 21 (29%)<br>2. Гүйлсэн булчирхайн архаг үрэвсэлтэй 40 (54%)<br>3. Хамар, хамар дайврын үрэвсэлтэй 11 (16%)<br>4. Шүд каристай 6 (10%)<br>5. Чихний архаг үрэвсэлтэй 1 байна.<br>• **Дотоод шүүрлийн үзлэг:** Нийт **146 хүүхдэд** урьдчилан сэргийлэх үзлэг хийснээс илүүдэл жинтэй 15 (10.3%) хүүхэд, таргалалттай 6 (4.1%) хүүхэд байсан.<br>• Насны байдлаар нь авч үзэхэд 11-12 настай нийт 78 хүүхдээс:<br>1. Илүүдэл жинтэй 8 /10,2%/<br>2. Таргалалттай 4 /5,12%/<br>• Үзлэгт 15 настай нийт 68 хүүхэд хамрагдсанаас:<br>1. Илүүдэл жинтэй 7 /10,29%/<br>2. Таргалалттай 2 /2,94%/ байна.<br>• Сургуульд суурилсан эрт илрүүлгийн судалгааны тайлан болон зөвлөмжийг ЭМЯ-нд хүргүүлсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.8 | Орон нутгийн мэс заслын эмч нарыг хүүхэд, нярайн яаралтай мэс заслын мэргэшүүлэх сургалтанд хамруулна | - | Сургалтанд хамрагдсан хүний тоо | 3 | 5 | 6. ЭМС-ын Төвлөрлийг бууруулах ажлын хүрээнд, “Хүүхэд нярайн мэс заслын тусламжийг сайжруулах” ажлын хүрээнд 6 тасаг (ЧХХМЗТ, МХНТ, ННТ, ЕМЗТ, ЦМЗТ, БМЗТ)-ийн хамтарсан баг Ховд, Увс аймагт ажиллаж, тус бүрийн төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр орон нутгийн эмч нарыг ажлын байран дээр чадавхижуулах сургалт хийсэн.<br>7. 2024-2025 оны хичээлийн жилд **3 эмч** “Хүүхдийн мэс засал судлал” чиглэлээр мэргэшил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж амжилттай суралцан төгссөн.<br>8. “Хүүхдийн мэс засал судлал” чиглэлээр **2 их эмч**, “Хүүхдийн чих хамар хоолой судлал” чиглэлээр **1 их эмч**, “Хүүхдийн нүд судлал” чиглэлээр **4 их эмч** суралцаж байна. Нийт **10 эмч сургалтад** хамрагдсан. | 100% |
| 1.1.9 | Хүүхэд, нярайн яаралтай мэс заслыг орон нутагт нутагшуулж, ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулна | - | -Сургалтанд хамрагдсан хүний тоо<br>-Зохион байгуулсан сургалтын тоо | Хүний тоо<br><br>3 удаа | 500 хүн<br><br>6 удаа | • **2025 онд нийт 7 удаагийн сургалт зохион байгуулсан. 500 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.**<br>• “Орон нутагт хүүхэд, нярайн мэс заслын тусламжийг сайжруулах нь” сэдэвт семинар, ажлын байран дээрх сургалт = 4. (Увс, Ховд, Завхан, Баян-Өлгий)<br>• Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилгоор ЭХЭМҮТ-өөс Эмнэлзүй эрхэлсэн тэргүүн дэд захирлаар ахлуулсан баг 2025.03.14-18 өдрүүдэд Ховд аймгийн БОЭТ-д, 2025.05.02-06 өдрүүдэд Увс аймгийн нэгдсэн эмнэлэгт, 2025.10.14 -18 өдрүүдэд Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэгт сургалт зохион байгуулах, хүүхэд, нярайн мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлэх гэсэн 2 чиглэлээр ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1. Орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжил арга зүйг сайжруулах зорилгоор "Хүүхэд, нярайн мэс заслын тусламжийг сайжруулах нь" сэдэвт сургалтыг зохион байгуулж, аймаг, сум, баг, өрхийн нийт **500 эмч** хамрагдсан.<br>2. Эмч, эмнэлгийн мэргэжилтэнг чадавхижуулах ажлын хүрээнд орон нутгийн эмч нартай хамтран 85 орчим өвчтөнд мэс засал эмчилгээ хийж, 260 хүүхдэд үзлэг, оношилгоо хийсэн.<br>• Энэ үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд “Скайтел” ХХК ивээн тэтгэсэн.<br>• 2025.06.09-16 өдрүүдэд 3 тасаг (ЭНМЗТ, БМЗТ, МХНТ)-ийн эмч нарын хамтарсан баг Завхан аймагт очиж ажиллан эрүү нүүрний мэс засал нийт үзлэг 44, хагалгаа 23 хийгдсэн. Бөөрний мэс засал нийт үзлэг 40, хагалгаа 21, нийт хамтарсан багаар 84 хүүхдэд үзлэг хийж, 43 мэс засал хийсэн байна.<br>• ЭНМЗТ нь 2025 оны 7-р сард Өвөрхангай аймагт сургалт хийж 23 мэс засал эмчилгээ, 2025 оны 8-р сард Баян-Өлгий аймагт сургалт хийж 27 мэс засал эмчилгээ хийгдсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.10 | Ургийн пренатал илрүүлэг, оношилгоонд дараа үеийн секвенс ашиглан ургийн чөлөөт ДНХ-ийг эхийн цусанд тодорхойлох дэвшилтэт техонологийг эмнэлзүйд нэвтрүүлнэ | 1,4 тэрбум төгрөг | Шинжилгээнд хамрагдсан хүний тоо | - | 42 | • Ургийн чөлөөт ДНХ-ийг тодорхойлох боломжтой NextSeq550 (Illumina) дараа үеийн секвенсийн багажийг худалдан авах үйл ажиллагааг ЭМЯ-наас зохион байгуулж суурилуулсан.<br>• НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр тандем масс спектрометрийн аппаратыг 2025 оны 10-р сарын 01-ний өдөр хүлээн авч, суурилуулалтын ажлыг хийж байна. Тус технологи нь 2025 онд шинээр нэвтрүүлсэн шинэ технологи юм.<br>• Шинжилгээ хийх лабораторийн өрөөнүүд барилгын их засвар хийгдэж байна.<br>• Эдгээр шинэ технологийг нэвтрүүлснээр Монголд улсад оношлох боломжгүй байсан амин хүчил, органик хүчил, митохондрийн өөхний хүчлийн солилцоо, шүвтрийн солилцооны эмгэг зэрэг 30-аад өвчнийг ЭХЭМҮТ-д эмчлэх боломжтой болж байна. | 100% |
| **Зорилт 1.2. Тус төвд шинэ технологи нэвтрүүлнэ.** | | | | | | | |
| 1.2.1 | БСТ-1.2.3.2. Урагт шунт тавих эмчилгээг нэвтрүүлнэ. | - | Заалттай бүхий тохиолдолд хийсэн мэс заслын тоо | 5 | 5 | • 2022 онд “Ихэр ургийн артерийн эсрэг урсгал үүсэх эмгэгийг эмчлэх эмнэлзүйн заавар” батлагдсан.<br>• Тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч, мэргэжилтнүүд бэлтгэгдсэн.<br>• Эмчилгээнд шаардлагатай шунтыг худалдан авах ажиллагааны захиалгад санал хүргүүлсэн.<br>• Олон улсад 10,000 амьд төрөлтөнд 3,6 тохиолддог. Тайлант хугацаанд заалт бүхий тохиолдол гараагүй. | Заалт бүхий тохиолдол гараагүй |
| 1.2.2 | БСТ-1.2.3.3. Ургийн цус сэлбэх эмчилгээг нэвтрүүлнэ. | - | Заалттай бүхий тохиолдолд хийсэн мэс заслын тоо | 5 | 10 | • 2022 онд “Ургийн цус багадах эмгэгийн үед даршилсан улаан эс сэлбэх эмчилгээ эмнэлзүйн заавар” батлагдсан.<br>• Тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч, мэргэжилтнүүд бэлтгэгдсэн. | Заалт бүхий тохиолдол гараагүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Тайлант хугацаанд заалт бүхий тохиолдол гараагүй. | |
| 1.2.3 | БСТ-1.2.3.6. Үргүйдэл, нөхөн үржихүйн тусламжид оношилгооны гистерскопийг нэвтрүүлнэ. | - | Үйлчлүүлэгчийн тоо | 5 | 10 | • Оффис гистероскопийн багаж дутуу. Эмэгтэйчүүдийн мэс заслын тасагтай хамтарч 13 тохиолдолд гистероскопи, лапораскопи хийсэн байна. | 100% |
| 1.2.4 | БСТ-1.1.4.5. Хүүхдэд тархи, мэдрэлийн төрөлжсөн мэс заслын тусламжийг нэвтрүүлнэ. | - | Заалттай бүхий тохиолдолд хийсэн мэс заслын тоо | 5 | 10 | • 2025.05-р сарын 03, 10, 17, 24-ний өдрүүдэд “Эрхэм нандин сувд” ТББ-ын санаачилгаар ЭМЯ, ГБХНХЯ, ЭХЭМҮТ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран тархины саа, аутизм, уналт таталт, тархины усжилт, тархины үйланхай, хромосомын эмгэг, оюуны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан үзлэг, оношилгоог ЭХЭМҮТ-д 4 дэх жилдээ буюу 6 дахь удаагаа зохион байгуулсан.<br>• Энэхүү цогц үзлэгт УГТЭ-ийн мэдрэлийн мэс заслын эмч нар, Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн хүүхдийн мэс заслын эмч нар, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн эмч нар хамтран ажилласан.<br>• Үзлэгт 0-18 насны 639 хүүхдийг хамруулж, давхардсан тоогоор 2161 үзлэг, оношилгоо хийсэн.<br>• Эдгээр хүүхдүүдээс 12 хос мэдрэлийн мэс заслын хагалгаанд орох 12 хүүхдээс **8 хүүхдэд мэс засал хийх заалт гарч 3 хүүхдэд мэс засал** хийгдсэн.<br>• 20 оны 5, 9-р сард АНУ-ын “Neurosurgery Outreach Foundation” сан, мэдрэлийн мэс заслын эмч Флип Алдана эмчтэй хамтран ажиллаж, ЭХЭМҮТ-д 80 хүүхдэд үзлэг оношлогоо хийж, 6 нярай хүүхдэд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ЭХЭМҮТ-д 3 хүүхдэд ризотоми мэс засал хийсэн.<br>• ЭХЭМҮТ-ийн шинэ бүтцэд хүүхдийн мэдрэлийн мэс заслын шинэ тасгийг байгуулсан. 2025 онд **мэдрэлийн мэс заслын 55 мэс заслын** хийсэн.<br>• “Хүүхдийн мэдрэлийн эмгэгийн оношилгоо эмчилгээ” сэдэвт улсын хэмжээнд зохион байгуулсан сургалтанд “Тархины усжилтын үеийн мэс засал эмчилгээ”, “Эпилепсийн мэс засал эмчилгээ”, “Мэдрэлийн арын ёзоор тайрах мэс засал эмчилгээ”, “Тэнэгч мэдрэлийн цочроох мэс засал эмчилгээ” гэсэн сэдвүүдээр зочин эмч нар лекц уншсан. Уг сургалтанд 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэг, өрхийн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 110 эмч хамрагдсан.<br>• АНУ-ын “Neurosurgery Outreach Foundation” сан ЭХЭМҮТ-ийн хүүхдийн ерөнхий мэс заслын тасагт мэс заслын багаж болон нэг удаагийн хэрэгслийг хандивласан. | |
| 1.2.5 | БСТ-1.1.1.2. Дутуу нярайн уушги гэмтэхээс сэргийлэх өндөр давтамжит аргаар (HFO) амьсгалуулах эмчилгээг нэвтрүүлнэ. | 150 сая төгрөг (Улсын төсөв) | Аппарат, системын тоо | 3 | 4 | • Дутуу нярайг уушги гэмтэхээс сэргийлэх өндөр давтамжит аргаар (HFO) амьсгалуулах эмчилгээг 2 төрлөөр хийж байна. Үүнд:<br>1. HFOV-Өндөр давтамжит осцилляторын аргаар сэлэгцэл хийн амьсгал дэмжих эмчилгээг дутуу төрсөн **5 нярайд** хийсэн. Уушигны артерийн даралт ихсэлт оноштой дутуу төрсөн **1 нярайд**, бронх-уушигны дисплазитай дутуу төрсөн **4 нярайд тус тус амжилттай** хийсэн.<br>2. (NIV/HFNC)-Өндөр урсгалаар чийгшүүлэн бүлээсгэн хүчилтөрөгч эмчилгээ 100% хийдэг болсон. Тус эмчилгээг 1500 граммаас доош | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | жинтэй **65 дутуу нярайд амьсгалын аппаратнаас гаргасны дараах үед хэрэглэж хэвшсэн нь үр дүнтэй байна.**<br>• ЭМЯ-нд HPO горимтой амьсгалын аппаратны техникийн техник үзүүлэлтийг боловсруулан хүргүүлсэн. ЭМЯ-ны захиалгаар Төрийн худалдан авах ажиллагааны газраас ЭМЯ/20250102012 дугаартай тендер шалгаруулалтыг зарласан боловч 2025 оны төсвийн зардлын хэмнэлтийн хүрээнд 2026 он руу шилжин дараа онд нийлүүлэгдэх төлөвлөгөөнд ороод байна. | |
| 1.2.6 | БСТ-1.1.1.3. Хүчилтөрөгч-агаарын холимгоор амьсгалуулах блиндерийн системийг Нярайн эмгэг судлалын тасагт хүчилтөрөгч эмчилгээнд ашиглана | - | Хүчилтөрөгч-агаарын холимгоор амьсгалуулах блиндерийн системтэй өрөөний тоо | 3 | 5 | • 2025 оны эхний 10 сарын **байдлаар 63 нярайн хүчилтөрөгч эмчилгээнд хүчилтөрөгч-агаарын холимгоор амьсгалуулах блиндерийн системийг** 6 нярайд үр дүнтэй хэрэглэсэн.<br>• 2025 оны 10 сард Орбис төслийн хүрээнд 5 блендерийн системтэй болсон бөгөөд цаашид уг системийг хүчилтөрөгч-агаарын төгсгөлд холбон илүү олон нярайд уг эмчилгээг хийх боломжтой болно. НСТ-т хүчилтөрөгч-агаарын холимгоор амьсгал дэмжих 2 системийг хүчилтөрөгч агаарын төгсгөлд холбон 20 нярайд амьсгал дэмжсэн. | 100% |
| 1.2.7 | БСТ-1.1.3.4. Хүүхдийн хавдрыг эд, эсийн түвшинд шинжлэх иммуногистохимийн шинжилгээг эхлүүлнэ | - | Шинжилгээний тоо | 20 | 30 | • Хүүхдийн хавдар, хавдрын урьдал болон хавдар төст, хавдрын бус эмгэгийг ялган оношилгоонд давхардсан тоогоор **нийт 131 шинжилгээ** хийгдсэн. Үүнээс 23 төрлийн маркерийг давхардсан тоогоор 260 удаа ашигласан бөгөөд үүнээс 137 эерэг, 123 сөрөг гарсан байна.<br>• Хавдар, хавдрын урьдал, хавдар төст 28 нэршлийн, 80 тохиолдол, хавдрын бус 19 нэршлийн, 43 тохиолдол, бусад 2 нэршлийн, 17 тохиолдол бүртгэгдсэн байна.Үүнд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1. Хавдар, хавдрын урьдал, хавдар төст – 28 нэршил, 80 тохиолдол<br>2. Лейкеми /миелолейкоз, лимфобласт/, Т болон В эсийн лимфома – 14<br>3. Остеосаркома – 6<br>4. Хавдрын бус – 19 нэршил, 43 тохиолдол<br>5. Урвалж лимфаденопати, фолликулын гиперплази, халдварт мононуклеоз, архаг тонзиллит – 9<br>6. Фиброзт дисплази – 9<br>7. Кикүчи өвчин – 6<br>• **Архаг шархлаа**, буглаа, цочмог үхжил, шархлааны өнгөр, шархлааны грануляц эд, сорвижил, урвалж гажигшил–7, Эмгэг өөрчлөлтгүй /хришпрунгийн өвчин үгүйсгэсэн/ – 10 | |
| 1.2.8 | БСТ-1.2.1.7. Ургийн халдварыг оношлох зорилгоор ураг орчмын шингэнд цитомегаловирусыг илрүүлэх шинжилгээг эхлүүлнэ | 60,0 сая.төг (Улсын төсөв) | Шинжилгээний тоо | 30 | 50 | • Ургийн халдварыг оношлох зорилгоор ураг орчмын шингэнд цитомегаловирусыг илрүүлэх шинжилгээг хийх ПГУ аппаратыг 2025 оны 09 дүгээр сард суурилуулсан.<br>• 2025 оны 12 дугаар сард багтаан оношилгоо, шинжилгээнд ашиглах бэлтгэл ажлыг хангаж байна. | 50% |
| 1.2.9 | БСТ-1.1.4.4. Хүүхдэд эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг тусламж, үйлчилгээнд нэвтрүүлнэ | 17,6 сая.төг (Улсын төсөв) | Амжилттай хийсэн элэг шилжүүлэн суулгах мэс заслын тоо | 5 | 10 | • 2025 онд ЭХЭМҮТ-д амьд донороос 2 хүүхдэд элэг шилжүүлэн суулгах мэс засал, нийт өссөн дүнгээр Монгол улсад **13 хүүхдэд элэг шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай** хийсэн. | 100% |
| | | | Амжилттай хийсэн бөөр шилжүүлэн суулгах мэс заслын тоо | 1 | 2 | • Монгол улсад 410, хүүхдэд 16 удаа, УНТЭ болон ЭХЭМҮТ-ийн бөөр шилжүүлэн суулгах баг хамтран амьд донороос **хүүхдэд бөөр шилжүүлэн суулгах мэс засал 2025 онд 2 тохиолдолд амжилттай хийгдсэн**.<br>• 1-р тохиолдол: Донор ээж 43 настай эмэгтэй зүүн бөөр. Реципиен охин 13 эмэгтэй баруун талд суугдсан. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2-р тохиолдол: Донор ээж 40 настай зүүн бөөр, реципиент охин 15 настай, баруун талд суугдсан. | |
| 1.2.10 | БСТ-1.1.2.3. Бамбай булчирхай, бөөрний эдийн биопсийн шинжилгээг нутагшуулна. | - | Үйлчлүүлэгчийн тоо | 15 | 20 | • | • 2025 онд бамбай булчирхайн биопсийн шинжилгээ 8 хүүхдэд хийж, онош тодруулан эмчилгээг эхлүүлсэн.<br>• ЭХЭМҮТ-д бамбай булчирхайн биопсийн шинжилгээ бүрэн нутагшиж чадсан.<br>• “Хүүхдийн бөөрний эдийн шинжилгээ” хийгээгүй. | 40% |
| 1.2.11 | БСТ-1.1.2.4. Булчингийн бичлэгийн шинжилгээг хүүхдийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх | - | Үйлчлүүлэгчийн тоо | 15 | 20 | • | • 2025 онд **булчингийн бичлэг шаардлагатай 10 хүүхдийг** төв дээрээ**, 70 хүүхдийг** Рефлекс болон Сэцэн мед эмнэлэгт хийлгэн оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэсэн байна. | 100% |
| 1.2.12 | БСТ-1.1.1.1. Хүчилтөрөгч-цусан хангамжийн дутагдлын шалтгаант энцефалопатитай нярайд эрт үед гипотерм (хөргөөх) -ийн эмчилгээг нэвтрүүлэх. | 81,0 сая.төг (Улсын төсөв) | Үйлчлүүлэгчийн тоо | 5 | 10 | • | • Гүйцэт нярай, дутуу нярайн эрчимт эмчилгээний тасагт 2025 оны эхний 10 сарын байдлаар тархи хөргөөх эмчилгээний өмнөх үе шат болох нярайн тархины цахилгаан бичлэгийг 34-40 долоо хоногтой, 2500 граммаас дээш жинтэй **12 нярайд хийж** үнэлгээ өгсөн.<br>• Тархи хөргөөх эмчилгээний заалттай **8 нярайд гипотерм (хөргөөх)-ийн эмчилгээ хийснээс 1 нярайн эмчилгээ үр дүнтэй** болсон. | 100% |
| 1.2.13 | БСТ-1.1.3.5. Хүүхдэд ясны чөмөг шилжүүлэн суулгах мэс заслыг нэвтрүүлнэ | - | Амжилттай хийсэн мэс заслын тоо | 3 | 5 | • | • 2025.04.25-ны өдөр ЭМХТ-ийн Эс, эд эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны хүмүүстэй хийсэн уулзалтад хүүхдэд үүдэл эс шилжүүлэн суулгахад шаардлагатай хүний нөөцийг багаар нь сургахад дэмжлэг үзүүлэх талаар саналаа хэлсэн.<br>• 2025.05.19-нд УНТЭ, ЭХЭМҮТ, Medical Park эмнэлгийн төлөөлөл уулзалт хийж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр санал солилцлоо. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд болсон уулзалтаар Туркийн Medical Park эмнэлэг, УНТЭ болон ЭХЭМҮТ-ийн удирдлагууд болон цусны эмгэг судлалын мэргэжилтнүүд оролцлоо. Уулзалтын үеэр талууд өмнөх хамтын ажиллагааг дүгнэн ярилцаж, хамтын ажиллагааг дараагийн шатанд хүргэх, цаашид хамтран ажиллах шинэ салбар чиглэлүүдийг өргөжүүлэх талаар санал солилцсон. 2 эмч, 2 сувилагчийг Турк улсад сургах гэрээ хийсэн.<br>• ЭХЭМҮТ-ийн ТИКА-тай ярилцаж сургалтанд хамтарч ажиллахаар тохирсон.<br>• ЭХЭМҮТ-ийн захирлын 2025.05.14-ний өдрийн А/67 дугаар тушаал “Хүүхдэд цусны үүдэл эс болон ясны чөмөг шилжүүлэн суулгах багийн бүрэлдэхүүнийг томилох, багийн ажиллах журмыг батлах тухай” гарсан.<br>• **2025 оны 12-р сарын 09-ний өдөр М.М 15 настай эмэгтэй цусны хавдартай хүүхдэд ясны чөмөг-үүдэл эс шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээг Монгол улсад анх удаа Туркын Medical эмнэлэг болон УНТЭ-т шилжүүлэн хамтарсан багаар амжилттай хийлээ.** | |
| **1.3 Эрүүл мэндийн ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулна** | | | | | | | |
| 1.3.1 | Эрүүл мэндийн сайдын А/406 дугаар тушаал “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийг баримтлан ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | 5,5 сая.төг (Улсын төсөв) | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | 100% | • 2025 оны А/17 дугаар тушаалаар ЭХЭМҮТ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороог байгуулж ЭМЯ-ны дэргэдэх Ёс зүйн хяналтын хороонд хүргүүлсэн.<br>• ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2025 оны 25/08 дугаар тогтоолоор ЭХЭМҮТ-ийн дэргэдэх эмнэлгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэжилтний ёс зүйн салбар хороог 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаанд томилж, баталгаажуулсан.<br>• Төрийн албан хаагчийн тухай хуулийг чанд мөрдүүлэх, эмч мэргэжилтэнгүүдэд хуулийг сурталчилах, ёс зүй харьцаа хандлагыг бүх шатанд дээдлэх **тухай 7 заалт 4 бүлэг, 18 ажлын төлөвлөгөөг** Төвийн захирлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, 2025 оны эхний хагас жилийн ажлын тайланг ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд хүргүүлэн ажилласан.<br>• 2025 оны 11 дүгээр сарын 17-ны байдлаар Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд **нийт 10 өргөдөл**, гомдол ирснийг хуулийн хугацаанд хэлэлцэн шийдвэрлэж **6 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах саналыг** Хүний нөөцийн албанд хүргүүлж, **4 өргөдлийг эвлэрүүлэн зуучилсан.**<br>• Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо нь 2025 онд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх зорилгоор **8 удаагийн сургалт** зохион байгуулж **нийт 861 албан хаагч** хамрагдсан байна. Үүнээс 2 нь багц цагийн сургалт байсан бөгөөд 338 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. 6 нь ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн сургалт байсан ба сургалтад 523 албан хаагч хамрагдсан байна.<br>• Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр Төвийн гадаад вэб хуудсанд ёс зүйн салбар хорооны гишүүдийн танилцуулга, ёс зүйн дүрэм журмууд, хийх ажлыг төлөвлөгөөг байршуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулахаа **“Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлье” сэдэвт 2 сарын аяныг 2025.10.23 - 2025.12.23-ны хооронд зохион байгуулахаар** удирдамжийг гарган, нийт тасаг нэгжид хүргэж ажиллаж байна.<br>• Ёс зүйн салбар хороо нь 2025 оны 11 дүгээр сарын 17-ны байдлаар **12 удаа хуралдаж**, сар бүр гишүүдийн гүйцэтгэсэн ажил үүрэг болон ирсэн өргөдөл гомдлыг хэлэлцэж ажилласан.<br>• Мэргэжлийн зэргийн шалгалтад **орох 52 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд** ёс зүйн салбар хорооны тодорхойлолт олгосон. 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний хяналтын хорооны дэмжлэгт шалгалт ирж, заавар зөвлөгөө өгч ажилласан. | |
| 1.3.2 | ЭХЭМҮТ-ийн “Харилцагчийн үйлчилгээний стандарт (ХҮС)”, “Эмнэлгийн дотоод албан харилцааны стандарт”-ыг хэрэгжүүлнэ. | - | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | • 2025 онд шинээр ажилд орсон ажилтанд “Үйлчилгээний стандарт, албан харилцааны стандарт” сэдвээр 3 удаагийн сургалт зохион байгуулсан. 110 эмч, эмнэлгийн ажилтан хамруулсан.<br>• Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын сургалтыг 5 тасгийн ажилтнуудад 6 удаагийн сургалтыг зохион байгууллаа. 15 хүн хамрагдсан.<br>• Төвийн угтах үйлчилгээний ажилтнууд хүүхдийн эмнэлгээр 43,810, эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгээр 25,529 нийт 69,339 үйлчлүүлэгчдэд угтах, лавлах, үдэх үйлчилгээг үзүүллээ. | 100% |
| 1.3.3 | Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай | - | Хяналт, зөвлөмжийн тоо | 50 | 55 | | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбоотой стандарт, дүрэм, журам, удирдамж, заавар хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний боловсруулан хэрэгжүүлнэ. | | Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 100% | 100% | • Хийгдсэн хяналт үнэлгээний тоо 27 (үүнээс төлөвлөгөөт 18, төлөвлөгөөт бус 9).<br>• Дэмжлэгт хяналт үнэлгээнд хамрагдсан тасгийн тоо=53 (давхардсан тоогоор);<br>• Тасгуудад өгсөн зөвлөмжийн тоо =35<br>• Хариу арга хэмжээний тайлан, зөвлөмжийн хэрэгжилт = 100%;<br>• Хяналт хийгдсэн чиглэл = 27. Үүнд:<br>1. Хүүхдийн эмнэлгийн эмчилгээний тасгуудын мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хадгалалт, хэрэглээ, зарцуулалтанд хийсэн төлөвлөгөөт дэмжлэгт хяналт;<br>2. Хүүхдийн эмнэлгийн тасгуудын цус, цусан бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, хэрэглээ, зарцуулалтанд хийсэн төлөвлөгөөт дотоод хяналт;<br>3. Хүүхдийн эмнэлэгт хэрэглэгдэж буй оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн зааврын өнөөгийн байдалд хийсэн дэмжлэгт хяналт;<br>4. Хүүхдийн эмнэлгийн Яаралтай тусламжийн тасгийн процессын үнэлгээ;<br>5. Хүүхдийн эмнэлгийн тасгуудын яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт, бэлэн байдал, гардан үйлдлийн мэдлэг, дадлыг үнэлэх, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдалд хийсэн дэмжлэгт хяналт;<br>6. Хүүхдийн эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилчдын гарын эрүүл ахуй сахилтанд төлөвлөгөөт, дэмжлэгт хяналт;<br>7. Хүчилтөрөгчийн аюулгүй байдалд хийсэн дэмжлэгт хяналт; Эмнэлзүйн унах эрсдэлд хийсэн дэмжлэгт хяналт; | 100% |
| | | | Арга хэмжээний тайлан хэрэгжилтийн хувь | 100% | 100% | | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 8. ЭБЭЭ-ийн Төрөх тасагт төрөх үед нярайн эгэм хугарсан тохиолдолд хийсэн хяналт үнэлгээ;<br>9. ЭБЭЭ-ийн эмчилгээний тасгуудын мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хадгалалт, хэрэглээ, зарцуулалтанд хийсэн төлөвлөгөөт дэмжлэгт хяналт;<br>10. ЭБЭЭ-т яаралтай кесар мэс засалд орсон тохиолдлуудад хийсэн хяналт үнэлгээ;<br>11. ЭБЭЭ-ийн нийт 12 тасагт халдварын сэргийлэлт, хяналт, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын чиглэлээр хийсэн хяналт үнэлгээ (2025 оны 8 дугаар сард);<br>12. ЭБЭЭ-т 2025 оны 8 дугаар сард яаралтай орсон кесар мэс заслын бүтцийг судалсан хяналт үнэлгээ;<br>13. Нэгдсэн лабораторийн тасгийн үйл ажиллагаа;<br>14. Эмзүйн албаны үйл ажиллагаа зэрэг болно | |
| | | | Шинэчилсэн стандарт, дүрэм, журам, удирдамж, зааврын тоо | 40 | 60 | • ЭХЭМҮТ-д 2025 оны 10 дүгээр сарын байдлаар Ерөнхий захирлын тушаалаар батлагдсан **110 журам** мөрдөгдөж ажиллаж байна. Үүнд:<br>• ХЭ-52, ЭБЭЭ-41, Халдвар хяналтын алба А/173, А/193 тоот тушаалын дагуу-1, процессийн зураглалын дагуу-3, хугацаа дууссан байсан-6 зааврыг шинэчлэн боловсруулан батлуулсан. Лабораторит шинээр ашиглалтын заавар-2, стандарт ажиллагааны заавар-5 боловсруулж батлуулсан. | 100% |
| **Зорилт-2. Хүүхэд, нярайд лавлагаа шатлалын бүх төрлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг үндэсний хэмжээнд үзүүлнэ.** | | | | | | | |
| 2.1 | БСТ-1.1.2.2. Амьсгалын багтаамжийн | - | Үйлчлүүлэгчийн тоо | 20 | 30 | • Ерөнхий боловсролын сургуулиудад урьдчилан сэргийлэх үзлэгийг БГД-ийн “Сэтгэмж” сургуулийн 7, 10 дугаар ангийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээг тогтмолжуулна. | | | | | нийт **77 хүүхдэд спирометрийн шинжилгээ** хийсэн.<br>• Мөн АЭЭСТ, Амьсгалын эрхтний эмгэг судлалын кабинетад үзүүлж эмчлүүлж байгаа хүнд архаг өвчтэй хүүхдэд спирометрийн шинжилгээ тогтмол хийж байна. 2025 оны эхний 10 сарын байдлаар нийт 97 хүүхдэд спирометрийн шинжилгээ хийсэн. | |
| 2.2 | БСТ-1.1.2.5. Гемодиализын хүртээмжийг нэмэгдүүлж, гемодиализийн орчин үеийн тусламж (CRRT, плазмаферез)-ийн хувийг нэмэгдүүлнэ. | - | Үйлчлүүлэгчийн тоо | 1200 | 1300 | 2025 оны эхний 10 сарын байдлаар 29 эмчлүүлэгчид 1230 сеанс эмчилгээ хийсэн. Үүнээс:<br>• Тогтмол гемодиализ эмчилгээнд БАД-тай 10 хүүхэд хамрагдсан.<br>• ЭБЭЭ-ийн эрчимт эмчилгээний тасгаас бөөрний цочмог дутагдалтай - 2 эх,<br>• Бөөрний цочмог дутагдалтай - 9 хүүхэд,<br>• Чихрийн шижингийн кетоацидозтой - 1 хүүхэд,<br>• Эмийн хордолт - 7 хүүхэд орсон байна.<br>• Бөөр шилжүүлэн суулгах мэс засалд 2 хүүхэд ЭХЭМҮТ-д, 1 хүүхэд УНТЭ-д орсон. 2025 онд нийт 3 хүүхэд бөөр шилжүүлэн суулгах эмчилгээнд хамрагдсан.<br>• 2025 оны 09 сарын 10-ны өдөр ИХ МӨНХ НАРАН ХХК-ийн тусламжаар NCU-18 шинэ аппаратыг ЭХЭМҮТ-ийн удирдлагын багийн тусламж дэмжлэгээр хандиваар авч анхны гемодиализ эмчилгээг эхлүүллээ.<br>• 2025 оны 10 сарын байдлаар ХЭЭТ-т нийт 3 хүүхдэд CRRT эмчилгээ хийсэн. | 100% |
| 2.3 | БСТ-1.1.2.6. Хүүхдийн ревматологийн тусламжид биологийн бэлдмэлүүдийн хэрэглээг тогтмолжуулна. | - | Үйлчлүүлэгчийн тоо | 1 | 2 | • 2021-2024 онд Өсвөр үеийн хэрэх төст үений үрэвсэл, Барьцалдаат спондилоартрит оноштой нийт 50 хүүхдэд Скафо биологийн бэлдмэлийг хэрэглэснээр эмнэлзүйн болон лабораторийн ээнэгшилд удаан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаанд оруулж, эдгээр өөсөө дархлаат эмгэгтэй хүүхдүүдийн амьдралын чанарыг эрс дээшлүүлсэн.<br>• Үүний үр дүнд 2025 оноос уг биологийн бэлдмэлийн эмчилгээг эрүүл мэндийн даатгалд оруулж Барьцалдаат спондилоартрит оноштой 6 хүүхдэд нийт 60 удаагийн эмчилгээг амжилттай хийсэн.<br>• Мөн ХЗП-ийн ревматологийн кабинетийн хяналтанд Тогтолцооны чонон яр оноштой 15 хүүхдэд дархлаа дарангуйлах микофенолат мофетил эмчилгээг хийсэн нь үр дүн сайн байна. Нийт **21 хүүхэд эмчилгээнд хамрагдсан.**<br>• Өсвөр үеийн хэрэх төст үений үрэвсэл оноштой 95 хүүхдийг мөн хянаж Метатрексат ба дархлаа дарангуйлах эмчилгээг хийж, дахилт өгсөн эсвэл эмчилгээ үр дүнгүй тохиолдолд биологийн бэлдмэлийн эмчилгээнд оруулахаар хянан эмчилж байна. | |
| 2.4 | БСТ-1.1.4.2. Судсан дотуурх мэс ажилбар, катетер – ангиографийн оношилгоо, эмчилгээний төрлийг нэмэгдүүлнэ. | - | Амжилттай хийсэн зүрхний судсан дотуурх ажилбарын тоо | 50 | 60 | • 2025 оны эхний 10 сарын байдлаар нийт **87 хүүхдэд зүрх, судасны катетер-ангиографийн оношилгоо** 9 төрлийн зүрхний төрөлхийн гажгийн үед, зүрх судасны судсан дотуурх мэс заслыг зүрхний төрөлхийн гажиг, зүрхний олдмол гажиг, зүрхний шигдээс, титмийн цочмог дутал, чих хамар хоолойн судасны хавдар, тархины хавдар, тархины судасны эмгэг, бөөрний судасны эмгэг, элэгний хавдрын үед буюу нийт 9 төрлийн эмгэгийн үед хийж эмнэлзүйн практикт нутагшуулсан байна. Үүнээс:<br>1. Артерийн битүүрээгүй цоргыг окклюдерээр хаах судсан дотуурх эмчилгээ -18, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Уушгины артерийн хавхлагийн хүнд зэргийн нарийслыг баллоноор тэлэх судсан дотуурх эмчилгээ-6,<br>3. Тосгуур хоорондын таславчийн цоорхойг – окклюдерээр хаах судсан дотуурх эмчилгээ-9,<br>4. Шигдээс, титмийн цочмог дутлын үеийн оношилгоо-3, тус тус хийгдсэн.<br>5. Улаан хоолойн ЭХоКГ –аар зүрхний оношилгоо-23 хүүхдэд, оношилгооны катетр-ангиографийг Ховдол хоорондын таславчийн цоорхой, Тосгуур хоорондын таславчийн цоорхой, Артерийн битүүрээгүй цорго, Фаллогийн дөрвөл, Уушигны артерийн хавхлагын нарийсал, Том судаснуудын солбио байрлал, 2 том судас баруун ховдлоос гарах гажиг, АВ канал, Баруун ховдлын дутуу хөгжил зэрэг нийт 9 төрлийн гажгийн үеийн оношилгоог нийт 63 хүүхдэд тус тус амжилттай хийгдсэн байна. | |
| | | | Амжилттай хийсэн бөөрний судсан дотуурх ажилбарын тоо | 10 | 15 | • Бөөрний судасны ангиографиийн оношилгоог **3 хүүхдэд** хийж онош тодруулсан байна. | 20% |
| | | | Амжилттай хийсэн элэгний судсан дотуурх ажилбарын тоо | 2 | 3 | Батлагдсан тохиолдол бүртгэгдээгүй. | |
| | | | Амжилттай хийсэн тархины судсан дотуурх ажилбарын тоо | 2 | 3 | • Тархины хавдартай **3 хүүхдэд тархины судсан дотуурх ажилбар** амжилттай хийсэн байна. | 100% |
| 2.5 | БСТ-1.1.4.3. Хүүхдийн дурангийн мэс заслын (чих, цээж, хэвлий, | | Амжилттай хийсэн чих хамар хоолойн мэс заслын тоо | 20 | 25 | • Чихний дурангаар чихний хэнгэрэг нөхөн сэргээх мэс заслыг **38 хүүхдэд** хийж чихний дурангийн мэс заслыг бүрэн нутагшуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бөөр, нярайн) төрлийг нэмэгдүүлнэ. | | | | | • Нийт дурангийн мэс засал /хамар, чих, залгиур/ 2024 онтой харьцуулахад 1.2%-иар нэмэгдсэн байна. | |
| | | | Амжилттай хийсэн цээж, хэвлийн хөндийн мэс заслын тоо | 45 | 50 | • 2025 онд ЦМЗТ 42, ЕМЗТ 96, нийт **138 дурангийн мэс засал** хийгдсэн. Үүнээс нярайн дурангийн мэс засал 7 хийгдсэн байна. | 100% |
| | | | Амжилттай хийсэн бөөрний мэс заслын тоо | 15 | 20 | • Хэвлийн дурангаар төмсөгний хураагуур судасны өргөсөлтийн үед Поломагийн аргаар судас боох, буугаагүй төмсөг хэвлийн байрлалтай үед дурангаар төмсөг буулгах мэс засал, бөөрний уйланхайг өөлж авах мэс засал зэргийг хийж байна.<br>• Давсагны уян дурангаар бөөр шээсний замын эмгэгүүдийг оношлогоог сайжруулсан. Үүнд : уян дурангаар бөөр шээлэйн гажгуудыг оношлох, нярай хүүхдийн давсаг шээлэй дурандах, бөөр давсагны чулууны оношлогоо эмчилгээнд түлхүү ашиглаж эхлээд байна.<br>• 2025 онд дурангийн мэс засал **18 хүүхдэд** хийгдсэн байна. | 90% |
| 2.6 | БСТ-1.1.4.7. Хүүхдийн ухархайн хавдрын мэс заслыг тогтмолжуулна. | - | Амжилттай хийсэн мэс заслын тоо | 15 | 20 | • **Ухархайн хавдрын тохиолдол бүртгэгдээгүй.**<br>• 2025 онд Торлог шилэнцрийн мэс засал 22, Болорын мэс засал 70, Ухархайн хугарлын нөхөн сэргээх мэс засал 6 тус тус амжилттай хийгдсэн.<br>• Болорын мэс заслын машин Legion-ийг хүлээн авснаар мэс заслын хүлээгдлийг бууруулан ажиллаж байна. | 100% |
| 2.7 | БСТ-1.1.4.8. Дунгийн суулгац, дотор чихний мэс заслын тоог нэмэгдүүлнэ. | - | Амжилттай хийсэн дунгийн суулгац, дотор чихний мэс заслын тоо | 15 | 20 | • ЭХЭМҮТ-д төрсөн 5820 нярай сонсголын скринингэд хамрагдсанаас чихний хөгжлийн төрөлх гажиг-23, сонсгол бууралт-38 оношлогдсон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Сонсгол бууралт илэрсэн 38 хүүхдээс **18 хүүхдэд агааржуулах гуурс тавих мэс засал эмчилгээ** хийгдээд байна.<br>• **6 хүүхдэд дунгийн суулгацын мэс засал**, эмийн эмчилгээ 8, сонсголын аппарат зүүсэн 13 тохиолдол байна. | |
| 2.8 | БСТ-1.1.4.10. Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний тасаг дахь өвчтөний хяналтыг нэмэгдүүлнэ. | - | Капнограф хяналтын тоо | 20 | 30 | • 2025 онд Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний тасаг ИВЛ дэмжлэгтэй **31 өвчтөнд** 188 хоног капнографийн хяналт хийгдсэн.<br>• Хагалгааны өрөөнд капнографийн хяналт хийгдэж байна. BIS хяналт 5 хийгдсэн. | 100% |
| 2.9 | БСТ-1.1.4.9. Хүүхдийн дуу судлалын кабинетыг байгуулна | - | Үйлчлүүлэгчийн тоо | 50 | 100 | • Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Хүүхдийн амбулаторийн шинэ барилгын 2 давхарт Хүүхдийн дуу судлалын кабинетийг байгуулсан.<br>• Тайлант хугацаанд **37 хүүхдэд дуу авиа судлалын тусламж үйлчилгээг** үзүүлсэн.<br>• Кабинетад ажиллах эмчийг Хүзүү толгой төвөнхөөр сургасан.<br>• Video-Laryngostroboscopy /VLS/-ийн аппаратыг ОУ-ын Ротари сангаас дэмжлэг тусламж авахаар төсөл бичиж хүргүүлсэн. Эхний шатанд төсөл дэмжигдсэн. | 60% |
| 2.10 | Хүүхдийн эмч нарын улсын зөвлөгөөн зохион байгуулна | - | Оролцогчдын тоо<br>Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмж | 0 | 1 | • 2025 онд аймаг, дүүргийн эмнэлгүүдийг оролцуулсан 4 удаагийн хүүхдийн эндэгдлийн хурлын цахим, амаржих газар, БОЭТ, АНЭ-ийг оролцуулан 12 удаагийн нярайн эрт үеийн цахим хурлыг тус тус зохион байгуулсан. Давхардсан тоогоор **1852 шийдвэр гаргагч болон эмч мэргэжилтэн оролцсон.** Хурлаар нийтэд болон холбогдох эрүүл мэндийн байгууллагад зөвлөмж өгчсөн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.11 | Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний сургалтыг орон нутагт зохион байгуулах | - | Сургалтанд хамрагдсан хүний тоо | 25 | 50 | • Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн сургалт 2025.12.11-12-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллагдлаа.<br>• Сургалтад аймаг, нийслэлийн 17 байгууллагын 50 эмч, эх баригчийг хамруулсан. | 100% |
| **Зорилт-3. Эх барих, эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн чиглэлээр лавлагаа шатлалын бүх төрлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг үндэсний хэмжээнд үзүүлнэ.** | | | | | | | |
| 3.1 | БСТ-1.2.1.2. Төрөлтийн үеийн өвдөлт намдаалтын хувийг нэмэгдүүлнэ. | - | Төрөлтийн үеийн өвдөлт намдаалтын хувь | 5% | 10% | • 2025.10.31-ний өдрийн байдлаар нийт 4699 эхтөрөх замаар төрсөн. Төрөлтийн 15%-д /705 эхэд/ төрөлтийн өвдөлт намдаалт хийсэн байна. | 100% |
| 3.2 | БСТ-1.2.1.3. Эрсдэлтэй бүлгийн эхийн төрсний дараах хяналтыг сайжруулна | - | Өндөр хяналтат өрөөний тоо Үйлчлүүлсэн хүний тоо | 3 | 4 | • Өндөр хяналтат 4 өрөөнд 689 эхэд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:<br>1. Дутуу тээлт судлалын тасагт өндөр хяналтат өрөө -1, үйлчлүүлсэн эхийн тоо – 201<br>2. Төрсний дараах тасагт өндөр хяналтат өрөө- 3, үйлчлүүлсэн эхийн тоо – 488 | 100% |
| 3.3 | БСТ-1.2.1. Төрсний дараах сэтгэл гутралын скринингийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | - | Сэтгэл гутралын скринингэд хамрагдсан үйлчлүүлэгчийн хувь | 30% | 50% | • 2025.10.31-ний өдрийн байдлаар дутуу төрөлт 676. Үүнээс 513 эхийг /нийт дутуу **төрөлтийн 76%**/ төрсний дараах сэтгэл гутралын Эдинбургийн сорилоор үнэлж, үнэлгээнээс хамаарсан тусламж үйлчилгээ, сэтгэл зүйчийн зөвлөгөөнд хамруулсан байна. | 100% |
| 3.4 | БСТ-1.2.2.1. Эмэгтэйчүүдийн хавдар, хөх, дотоод шүүрэл, урогинекологи, охидын амбулаторийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | - | Үйлчлүүлэгчийн тоо | 12000 | 13000 | • Эмэгтэйчүүдийн хөх, умай хүзүү судлалын кабинет 4789, хавдар, мэс заслын кабинет 7639, дотоод шүүрлийн кабинет 5311, урогинекологийн кабинетээр 2868 үйлчлүүлэгч, нийт **20,607** үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлэн оношилгоо шинжилгээнд хамруулсан байна.<br>• Өсвөр үеийн клиникийн үйл ажиллагаа гүйцэт явагдаж байгаатай холбоотойгоор | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | охидын тусламж үйлчилгээг тус клиникт төвлөрүүлэн ажиллаж байна. | |
| 3.5 | БСТ-1.2.1.5. Төрсний дараах нөхөн сэргээх эмчилгээг нэвтрүүлнэ | - | Төрсний дараах нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн хувь | 10% | 20% | • Тайлант хугацаанд нийт 6848 төрөлт байгаагаас 1462 эх буюу 21,3% нь төрсний дараа сэргээн засах тусламж үйлчилгээнд хамрагдсан. | 100% |
| 3.6 | БСТ-1.2.2.2. Эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслын төрөл, тоог нэмэгдүүлнэ. | - | Дурангийн мэс заслын эзлэх хувь | 10% | 15% | • Тайлант хугацаанд нийт эмэгтэйчүүдийн мэс засал 928 хийгдсэний 25,6% буюу 235 нь дурангийн мэс засал байна.<br>• Мэгтэйчүүдийн мэс засал дараах 8 төрлийн дурангийн мэс заслыг хийж байна. Үүнд:<br>1. Умай авах<br>2. Умайн хоргүй хавдрын зангилаа авах<br>3. Үрийн хоолой авах<br>4. Өндгөвч авах<br>5. Дайврын уйланхай авах<br>6. Эндометриозын голомт авах, түлэх<br>7. Үрийн хоолойн битүүрэл наалдац салгах<br>8. Бага аарцгийн наалдац салгах мэс засал | 100% |
| 3.7 | БСТ-1.2.2.4. Андрологийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | - | Үйлчлүүлэгчийн тоо | 900 | 1000 | • 2025.10.31-ий байдлаар ҮНҮТ-ийн нийт үзлэг 7844. Эрэгтэйчүүдийн үзлэг 1188 /нийт үзлэгийн 15,1%/ байгаагаас анхан эрэгтэй үзлэгийн тоо 448 байна.<br>1. хэвийн үзүүлэлттэй 322,<br>2. хөдөлгөөн удааширсан 49,<br>3. эр эсийн тоо цөөрсөн 31,<br>4. эр эс огт тодорхойлогдохгүй 36,<br>5. эр бэлгийн эсийн тоо цөөрсөн, хөдөлгөөн удааширсан 9 тохиолдол тус тус байжээ.<br>• Үргүйдэлтэй эрэгтэйн төмсөгний эдээс эр бэлгийн эс ялгаж авах мэс ажилбар 13 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тохиолдолд хийсэн бөгөөд 100% эр бэлгийн эсийг ялгаж авч хөлдөөсөн. | |
| 3.8 | БСТ-1.2.3.4. Үр шилжүүлэн суулгах эмчилгээний жирэмслэлтийн хувийг нэмэгдүүлнэ. | - | Үр шилжүүлэн суулгах эмчилгээний жирэмслэлтийн хувь | 16% | 25% | • **IVF – 17** тохиолдолд хийсэн. Үүнээс:<br>1. **freshET -** Шинэ өсгөвөрлөсөн үр хөврөлийг умайд шилжүүлэн суулгасан 9 тохиолдлын 2 (22.2%) нь;<br>2. **TET -** хөлдөөсөн үр хөврөл гэсгээж суулгасан 7 тохиолдлын 2 (28.5%) нь; нийт **IVF** /Үр шилжүүлэн суулгах эмчилгээ/-р **4 тохиолдол (23.5%)** амжилттай жирэмсэлсэн байна.<br>• Нийт жирэмсэлсэн тохиолдол - 29<br>1. IVF /Үр шилжүүлэн суулгах эмчилгээ/-р жирэмсэлсэн – 4<br>2. HRT /Даавар эмчилгээ/-р жирэмсэлсэн тохиолдол – 14<br>3. IUI /Үр цацах эмчилгээ/-р жирэмсэлсэн – 11<br>• **OPU -**30 эмэгтэйд өндгөн эс соруулах ажилбар хийснээс 28 (93.3%) тохиолдолд амжилттай өндгөн эс авсан.<br>• Нийт авсан 103 өндгөн эсээс үр хөврөлийн лабораторийн үр тогтолтын хувь **55.6%.** | 95% |
| 3.9 | БСТ-1.2.2.5. Бөглөрлийн шалтгаант эрэгтэйчүүдийн үргүйдлийн үед үрийн сувгийг залгаж нөхөн сэргээх хагалгааг нэвтрүүлнэ | - | Амжилттай хийсэн мэс заслын тоо | 3 | 5 | • Тайлант хугацаанд заалт бүхий 2 тохиолдолд мэс заслыг амжилттай хийсэн.<br>• Эмнэлзүйн заавар батлуулсан. Эмч мэргэжилтнүүд бэлтгэгдсэн.<br>• Үргүйдэлтэй эрэгтэйн төмсгөний эдээс эр бэлгийн эс ялгаж авах мэс ажилбар /TESE/ 13 тохиолдолд хийсэн бөгөөд 100% эр бэлгийн эсийг ялгаж авч хөлдөөсөн. | 50% |
| 3.10 | БСТ-1.2.3.5. Үргүйдэл, нөхөн үржихүйн тусламжид үр хөврөлийн лазер ажилбарыг нэвтрүүлнэ | - | Амжилттай хийсэн ажилбарын тоо | 1 | 5 | • Нөхөн үржихүйн туслах технологийн дэвшилтэт арга техникийг нэвтрүүлэх төсөлт ажлын хүрээнд үр хөврөлийг лазер хатчинг хийх ажилбарын | 40% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | протоколыг боловсруулах шатандаа явж байна.<br>• Харин лазерын аппарат болон процедурыг гүйцэтгэх машиныг худалдан авах үйл ажиллагаа хийгдээгүй. 2024 онд ЭМЯ-нд тоног төхөөрөмжийн жагсаалт дотор оруулж санал өгсөн. | |
| 3.11 | Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр шийдвэр гаргагч болон хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудад олон нийтийн оролцоо түншлэлийг нэмэгдүүлэх, ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах | 3,98 сая.төг | -Зохион байгуулсан ажил<br><br>- Оролцсон байгууллага | 0<br><br>0 | 1<br><br>10 | • 2025 онд Эхийн ноцтой хүндрэл, эндэгдэл, амьгүй төрөлт, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бүртгэн мэдээлж, эмнэлзүйч эмч нартай хамтран үндэсний хэмжээнд **нийт 16 удаа цахим хурал зохион байгуулахад 4159 эмч, мэргэжилтэн оролцсон байна.** Үүнд:<br>1. 2025 оны 01 дүгээр сарын 22-нд “Хүүхдийн нүдний эмгэгийн эрт илрүүлэг” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **80** эмч, мэргэжилтэн оролцсон.<br>2. 2025 оны 01 дүгээр сарын 29-нд “Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн өнөөгийн байдал, 2020-2024 он” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **135** эмч, мэргэжилтэн оролцсон.<br>3. 2025 оны 01 дүгээр сарын 31-нд “Эх барихын үжил” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **150** эмч, мэргэжилтэн оролцсон.<br>4. 2025 оны 02 дугаар сарын 24-нд “Эхийн ноцтой хүндрэл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх нь” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **168** эмч, мэргэжилтэн оролцсон.<br>5. 2025 оны 04 дугаар сарын 16-нд “Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн өнөөгийн байдал, 2021-2025 оны I улирал” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **516** эмч, мэргэжилтэн оролцсон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6. 2025 оны 04 дугаар сарын 16-нд “Эхийн ноцтой хүндрэл, эндэгдлийн өнөөгийн байдал, 2021-2025 оны I улирал” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **568** эмч, мэргэжилтэн оролцсон.<br>7. 2025 оны 06 дугаар сарын 06-нд “Нялхсын эндэгдлийн өнөөгийн байдал, 2021-2025 оны эхний IV сар” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **156** эмч, мэргэжилтэн оролцсон.<br>8. 2025 оны 06 дугаар сарын 06-нд “Эхийн ноцтой хүндрэл, эндэгдлийн өнөөгийн байдал, 2021-2025 оны эхний 4 сар” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **154** эмч, мэргэжилтэн оролцсон<br>9. 2025 оны 06 дугаар сарын 24-нд “Нярайн эндэгдлийн өнөөгийн байдал, 2021-2025 оны эхний V сар” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **280** эмч, мэргэжилтэн оролцсон.<br>10. 2025 оны 06 дугаар сарын 26-нд “Эхийн ноцтой хүндрэл, эндэгдлийн өнөөгийн байдал” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **386** эмч, мэргэжилтэн оролцсон.<br>11. 2025 оны 08 дугаар сарын 12-нд “Эхийн ноцтой хүндрэл, эндэгдлийн өнөөгийн байдал” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **392** эмч, мэргэжилтэн оролцсон.<br>12. 2025 оны 08 дугаар сарын 22-нд “Нярайн эндэгдлийн өнөөгийн байдал” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **225** эмч, мэргэжилтэн оролцсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 13. 2025 оны 09 дүгээр сарын 23-нд “Нярайн эндэгдлийн өнөөгийн байдал, 2021-2025 оны эхний 7 сар” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **132** эмч, мэргэжилтэн оролцсон.<br>14. 2025 оны 09 дүгээр сарын 23-нд “Эхийн ноцтой хүндрэл, эндэгдлийн өнөөгийн байдал” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **229** эмч, мэргэжилтэн оролцсон.<br>15. 2025 оны 10 дугаар сарын 28-нд “Эхийн ноцтой хүндрэл, эндэгдлийн өнөөгийн байдал” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **260** эмч, мэргэжилтэн оролцсон.<br>16. 2025 оны 10 дугаар сарын 31-нд “Хүүхдийн өвчлөл, эндэгдлээс сэргийлье” цахим хурлыг зохион байгуулсан. Уг хуралд **328** эмч, мэргэжилтэн оролцсон.<br>• Дээрх цахим хурлуудын мэдээллийг ЭХЭМҮТ www.ehemut.mn, ЭМЯ-ны www.mohs.gov.mn вэб сайт, ЭХЭМҮТ, Тандалт судалгааны алба page хуудсанд байршуулсан.<br>• Өсвөр насныханд тулгамдаж буй эрүүл мэндийн өвөрмөц асуудлуудын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, анхаарлыг хандуулах, өсвөр үеийнхний эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн болон өсвөр үеийнхний өөрсдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ЭХЭМҮТ-өөс анх санаачлан 2019 оноос “Өсвөр үеийн эрүүл мэндийн 7 хоног”-ийн үйл ажиллагааг жил бүр уламжлал болгон зохион байгуулах болсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Өсвөр насныхан эсэн мэнд өсч хөгжин, эрүүл зан үйл, амьдрах ур чадвар бүхий насанд хүрэгч болоход нь нийгмийн бүх салбар дэмжлэг үзүүлэх, анхаарал хандуулах, оролцох шаардлагатай байна.<br>• 2025 онд ЭМЯ-ны удирдамжийн дагуу “Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё” сэдэвт өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих сарын үйл ажиллагааг 2025.04.15-ны өдрөөс 2025.05.15-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>• Аяны хүрээнд ЭХЭМҮТ-д хийх "Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё" сэдэвт өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих сарын нээлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган, батлуулж, төлөвлөгөөний дагуу дүүргүүдийн Эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн кабинетийн эмч, сувилагч нар, нийслэлийн өсвөр үеийнхний төлөөлөл охид, хөвгүүдийг урьж, нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулсан.<br>• Нийт 18 цахим постерийг боловсруулж, ЭХЭМҮТ-ийн нүүр номын хуудас, олон нийтийн сүлжээгээр түгээсэн.<br>• МҮОНТВ-ийн 2025.05.07 ба 2025.05.16-ны “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрийн “Эрүүл мэндийн булан” хэсэгт өсвөр үеийнхэнд тулгамдаж буй эрүүл мэндийн асуудал, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгсөн. | |
| **Зорилт 4. Эх, хүүхдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээн дэх лаборатори оношилгооны чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | |
| 4.1 | БСТ-1.2.3.7. Ургийн хромосомын эмгэгийн эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | 174,0 сая.төг | Үйлчлүүлэгчийн тоо | 4000 | 4500 | • 2025 оны эхний 10 сарын байдлаар 3788 үйлчлүүлэгчид (хоёрол тестийг 3699 үйчлүүлэгчид, гурвал тестээр 89 үйлчлүүлэгчид) шинжилгээ хийсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2 | БСТ-1.2.3.8. Пренатал оношилгоо, генетик шинжилгээний тоог нэмэгдүүлнэ. | 15,0 сая.төг | Үйлчлүүлэгчийн тоо | 250 | 300 | • 2025 оны эхний 10 сард 162 үйлчлүүлэгчид шинжилгээ хийсэн. 2024 оны цитогенетик шинжилгээний урвалж худалдан авах тендерт үнийн санал ирээгүйтэй холбоотойгоор урвалж нийлүүлэгдээгүй ба 2025 оны тендерийн урвалж 5 сараас нийлүүлэгдэж эхэлснээр 2025 оны II улирлаас эхлэн шинжилгээг хийн оншилгооны чанарыг сайжруулж байна.<br>• 2025 оны эхний 10 сард пренаталь Fish шинжилгээг ургийн усанд 22, хавдрын Fish 10 үйлчлүүлэгчид хийсэн. | 85% |
| 4.3 | БСТ-1.2.2.3. Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчин, бэлгийн замаар дамжих халдварын өвөрмөц үүсгэгчийн илрүүлэг, оношилгооны төрлийг нэмэгдүүлнэ. | - | Шинжилгээний нэмэгдүүлсэн төрлийн тоо | 5 | 7 | • PCR шинжилгээний аппаратаа шинэчилсэн. БНСУ-д үйлдвэрлэгдсэн BIORAD бүрэн автомат анализаторийг 2025 оны 10-р сард хүлээн авч оношилгоонд нэвтрүүлсэн.<br>• Шинэ аппаратад **14 нэр төрлийн үүсгэгч илрүүлэх ПГУ** шинжилгээ хийх боломжтой болсон.<br>• Одоогоор Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчин, бэлгийн замаар дамжих халдварын өвөрмөц үүсгэгчийн илрүүлэг шинжилгээ хийгдээгүй. Харин амьсгалын замын ПГУ-ын шинжилгээг 11 сарын 14-ний байдлаар **16 хүний сорьцонд вирусын 11 үзүүлэлт, бактерийн 8 үзүүлэлт шинжилгээ хийсэн. 8 хүнд А хүрээний вирус** буюу Respiratory Syncytial VirusA (RSVA), Parainfluenza Virus 3 (PIV 3), Influenza A H3N2 (Flu A-H3N2), Respiratory Syncytial Virus A (RSVA), Adenovirus (AdV) вирусууд зэрэг гарсан. 4 хүнд Streptococcus pneumoniae (SP) Haemophilus influenzae (HI) Moraxella catarrhials (MC), бактерийн халдвар илэрсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4 | БСТ-1.1.3.3. Хүүхдийн хавдрын цитогенетик шинжилгээг нэмэгдүүлнэ. | 4,0 сая.төг | Шинжилгээний нэмэгдүүлсэн төрлийн тоо | 3 | 4 | • АУЗЛ нь 4 FISH пробоор цусны хавдартай хүүхдэд цитогенетик шинжилгээ хийх боломжтой болсон.<br>1. BCR/ABL plus translocation dual fusion probe,<br>2. E2A/PBX1/HLF plus translocation dual fusion probe,<br>3. TEL/AML1 plus translocation dual fusion probe,<br>4. AML1/ETO plus translocation dual fusion probe, | 100% |
| | | | Үйлчлүүлэгчийн тоо | 20 | 30 | • 2025 оны эхний 10 сард 10 үйчлүүлэгчид цитогенетик шинжилгээг хийгээд байна. | 40% |
| **Зорилт-5. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулна.** | | | | | | | |
| 5.1 | БСТ-2.1.1.1. Эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг тогтмолжуулна. | - | Үйлчлүүлэгчийн тоо | 1000 | 1500 | • Тайлант хугацаанд ЭМДТ-ийн нийт үзлэг 5558. Үүнээс:<br>1. Жирэмсний хяналт – 764<br>2. Охид, эмэгтэйчүүдийн үзлэг – 2348<br>3. Төрсний дараах эхийн үзлэг – 1642<br>4. Урьдчилан сэргийлэх үзлэг – 804тус тус хийгджээ. | 100% |
| 5.2 | БСТ-2.1.1.3. Нярайн скринингийн төрөл ба хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | - | Нярайн скринингийн төрлийн тоо | 5 | 6 | • Нярайн скринингийн төрлийн тоо = 6<br>• Шинээр зулайн ЭХО скрининг хийж эхэлсэн.<br>• Жирэмсний 35 долоо хоногоос доош хугацаанд төрсөн, нийт 84 нярайд зулайн ЭХО скрининг хийгдсэн. Бүгд өөрчлөлттэй гарсан. Эдгээр хүүхдүүд Гүйцэт нярай, дутуу нярайн эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлсэн.<br>• ЭМЯ, НЭМГ, ЭХЭМҮТ, Өргөө амаржих газар, АШУҮИС-ын Хүүхдийн тэнхим хамтарч уулзан, скринингийг цаашид сайжруулах талаар хэлэлцүүлэг хийсэн. | 100% |
| | | | Хамрагдалтын хувь | 40 | 50 | • 2025 онд ЭХЭМҮТ-д амьд төрсөн нярай 6500.<br>• Нярайн скрининг шинжилгээнд хамрагдалт дунджаар **87.3%** байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Түнхний скрининг | 92% | 93% | • 2025 онд ЭХЭМҮТ-д 7738 нярай түнхний хэт авиан шинжилгээнд хамрагдсан.<br>• **Хамрагдалт 99%**. Үүнээс түнхний мултралын 2-р хэлбэр гэж оношлогдсон 1900 нярайн эцэг эхчүүдэд гарын авлага тарааж, үр дүнг тооцон ажиллаж байна. | 100% |
| | | | Сонсголын скрининг | 86% | 88% | • Сонсголын скрининг шинжилгээнд 5820 нярайг хамруулснаас чихний хөгжлийн төрөлх гажиг 23, сонсгол бууралт 38 хүүхдэд оношлогдсон.<br>• **Хамрагдалт 81%.**<br>• Сонсгол буурaлт илэрсэн 38 хүүхдээс 18 хүүхдэд агааржуулах гуурс тавих мэс засал эмчилгээ хийгдээд байна. 6 хүүхдэд дунгийн суулгацын мэс засал, эмийн эмчилгээ 8, сонсголын аппарат зүүсэн 13 тохиолдол байна. | 92% |
| | | | Ретинопатийн скрининг | 87% | 88% | • ЭХЭМҮТ-д 1950 ДНР-ийн скрининг үзлэг хийгдсэн ба (Анх 710, Давтан 1500) ДНР эмгэг илэрсэн 993 дутуу нярайг хянаж, 71 дутуу нярайд (Laser 12 ба Anti VEGF эмийн эмчилгээ 59) эмчилгээ хийгдсэн.<br>• **Хамрагдалт 90%**<br>• НУУР (нүдний угийн улаан рефлекс) ба нүдний гаж хөгжил илрүүлэх үзлэг = 1800 | 100% |
| | | | Зүрхний төрөлхийн гажгийн скрининг | 40% | 100% | • Нярайд зүрхний төрөлхийн гажгийг эрт илрүүлэх пульсоксиметрийн эрт илрүүлэг 2024.08.15-ны өдрөөс хийгдэж эхэлсэн.<br>• 2025 оны эхний 10 сарын байдлаар нийт 5272 нярайд хийсэн. Үзээгүй 978 нярай байна.<br>• **Хамрагдалт 81%.** | 81% |
| | | | Бодисын солилцооны скрининг | 10% | 20% | • Монгол улсад оношлогдож, бүртгэгдэж байгаагүй аминхүчил, органик хүчил, митохондрийн өөхний хүчлийн солилцоо, шүвтрийн солилцооны эмгэгийг оношилдог болох зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр тандем | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | масс спектрометрийн аппаратыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авч, суурилуулалтын ажлыг хийж байна. | |
| 5.3 | БСТ-2.1.1.4. Хүүхдийн хараа хамгаалах үндэсний сүлжээний II шатыг хэрэгжүүлнэ. | 78,5 сая.төг | Сүлжээнд хамрагдсан аймгийн тоо | 8 | 9 | | • 2025 онд ЭХЭМҮТ-д НУУР скрининг 1800 нярайд хийгдсэн байна.<br>• 2025 оны 03 сарын 27-нд **FORUS 3 Nethra Neo Camera багажны шинэ гар ба контакт линзийг хүлээж авсан.**<br>• ДНР ба нүдний угийн зураг авах техникч сувилагч бэлтгэгдэж байна. Нийт **302 дутуу нярайд нүдний угийн зураг авагдсан.**<br>• 2025.03.12-14 өдрүүдэд Хэнтий аймгийн ЭМГ-тай хамтран аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрх сумдын эмнэлэгийн хүүхэд нярай, нүдний эмч нарт “Хүүхдийн нүдний хэвийн ба хэвийн бус хөгжил, Нүдний угийн улаан рефлексийг үнэлэх, Хүүхдийн хараа шалгах, Дутуу нярайн хүчилтөрөгч эмчилгээ, Дутуу нярайн торлогийн эмгэг” сэдвээр 2 хоногийн лекц болон үзүүлэх сургалт, дадлага ажлыг амжилттай хийсэн. Сургалтанд Хэнтий аймгийн 22 сум, нэгдсэн эмнэлгийн хүүхэд, нярайн эмч нар, өрх, багийн эмч нар нийт 37 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцсон.<br>• 2025.03.19-21 өдрүүдэд Булган аймгийн аймгийн ЭМГ-тай хамтран аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрх сумдын эмнэлгийн хүүхэд нярай, нүдний эмч нарт “Хүүхдийн нүдний хэвийн ба хэвийн бус хөгжил, Нүдний угийн улаан рефлексийг үнэлэх, Хүүхдийн хараа шалгах, Дутуу нярайн хүчилтөрөгч эмчилгээ, Дутуу нярайн торлогийн эмгэг” сэдвээр 2 хоногийн лекц болон үзүүлэх сургалт, дадлага ажлыг амжилттай хийсэн. Сургалтанд Булган аймгийн 16 сум, нэгдсэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмнэлгийн хүүхэд ба нярайн эмч нар, өрх, багийн эмч нар нийт 27 эмч, эмнэлгийн мэргжилтнүүд оролцсон.<br>• 2025.03.17-19 өдрүүдэд Дорноговь аймгийн ЭМГ-тай хамтран аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрх сумдын эмнэлэгийн хүүхэд нярай, нүдний эмч нарт "Хүүхдийн нүдний хэвийн ба хэвийн бус хөгжил, Нүдний угийн улаан рефлексийг үнэлэх, Хүүхдийн хараа шалгах, Дутуу нярайн хүчилтөрөгч эмчилгээ, Дутуу нярайн торлогийн эмгэг" сэдвээр 2 хоногийн лекц болон үзүүлэх сургалт, дадлага ажлыг амжилттай хийсэн. Сургалтанд Дорноговь аймгийн 16 сум, нэгдсэн эмнэлгийн хүүхэд, нярайн эмч нар, өрх, багийн эмч нар нийт 32 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан.<br>• Сургалтанд хамрагдсан эмч бүрт<br>1. Arclight Ophthalmoscope and Otoscope<br>2. Хараа шалгах таблиц Lea Symbol chart<br>3. ДНР ба Дутуу төрөлт постер<br>4. Эцэг эхчүүдэд зориулсан ДНР-ийн зөвлөмж, карт хүлээлгэж өгсөн.<br>**Дүгнэлт**<br>• Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж буй өрх, сумын эмч нар ба аймгийн нүд болон нярайн эмч нарыг нэг баг болгож холбосон, хүүхдийн нүдний эмгэгийг эрт илрүүлэх болон тусламж үйлчилгээг хожимдолгүй авах, лавлагаа шатлалын эмнэлэгт цаг алдалгүй илгээх, сул хараа, сохролыг бууруулах нь нэн чухлыг эмч мэргэжилтэнүүдэд мэдлэг, мэдээлэл түгээсэн олон талын ач холбогдолтой сургалт боллоо.<br>• Дээрх аймгуудад хийгдсэн сургалтанд ороцогчдод 2 багц цагийн сургалтын батламж олгогдсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Нийт 2 аймагт 96 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, 94 ш Arclight Ophthalmoscope, 94 ширхэг хараа шалгах таблиц, хаалт хүлээлгэж өгөн хүүхдийн нүдний эмгэгийг илрүүлэх, нүдний угийн улаан рефлекс үзэх, нүдний угийн улаан рефлекс хэвийн бус бол яаралтай дараагийн лавлагаа шатлал руу илгээх, хүүхдийн хараа шалгах аргачлалаар суралцаж, хараа муутай хүүхдийг дараагийн төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг рүү илгээх тогтолцоонд суралцсан байна. | |
| 5.4 | БСТ-2.1.1.5. Өсвөр үеийн клиникийн үйлчлүүлэгчийн тоог нэмэгдүүлнэ. | - | Үйлчлүүлэгчийн тоо | 3000 | 3300 | • 2025 оны эхний 10 сарын байдлаар **6066** үйлчүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 82%-иар нэмэгдсэн байна.<br>• ЭБЭЭ-ийн Эрүүл мэндийг дэмжих төвөөр үйлчлүүлсэн 0-19 насны охидын үзлэг – **563**.<br>• Эх барихын тусламж үйлчилгээг **431** охидод үзүүлснээс:<br>1. Төрөлт-270<br>2. Жирэмсэнг хожуу хугацаанд шийдэх комиссын хурлаар хэлэлцсэн-26<br>3. Үр хөндөлт-135 | 100% |
| 5.5 | БСТ-2.1.2.1. Эмэгтэйчүүдийн хавдрын илрүүлэг, тусламж үйлчилгээг тогтмолжуулна. | - | Үйлчлүүлэгчийн тоо | 10% | 15% | • НҮЗП-ийн эмэгтэйчүүдийн кабинетаар үйлчлүүлсэн 20607. Үүнээс заалт бүхий 3934 тохиолдол буюу **19%-ийг хавдрын илрүүлэгт** хамруулсан.<br>• Эерэг-1013, умайн хүзүүний хавдар оношилогдсон-33 тохиолдол бүртгэгдсэн.<br>• Умайн хүзүү өөлөх эмчилгээ хийсэн (CIN I) – 69<br>• Байран өмөн оношоор мэс засал хийсэн (CIN II, III) – 18 | 100% |
| 5.6 | БСТ-2.1.2.2. Гэр бүл төлөвлөлтийн кабинетын үйл | - | Кабинетын тоо | 1 | 2 | • Сэргийлж болох эхийн болон перинатал эндэгдлээс сэргийлж үйл ажиллагааг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг нээж, ажиллуулна. | | | | | эрчимжүүлэх 2022-2027 төслийн хүрээнд Люксембургийн засгийн газар, ЭМЯ, НҮБХАС дэмжлэгтэйгээр “Гэр бүл төлөвлөлтын сургалтын төв” **үндэсний хэмжээний загвар 2 кабинет** байгуулсан.<br>• Мөн Люксембургийн зочид төлөөлөгчийг 2 удаа амжилттайгаар хүлээн авч сургалтын болон кабинетын үйл ажиллагаатай танилцсан.<br>1. ЖСАХ зөвөлгөө өгсөн тоо – 965<br>2. Сургагч багшаар бэлтгэсэн эх баригчийн тоо – 61<br>3. Эх баригч бие дааж суулгац, ерөндөг тавьсан тоо – 22 | |
| 5.7 | БСТ-2.1.2.3. Эх, хүүхдийн зайн оношилгооны төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, тогтмолжуулна. | - | Холболт хийгдсэн аймаг, нэгжийн тоо | 42 | 42 | • ЭХЭМҮТ нь лавлагаа шатлалын эх, эмэгтэйчүүд, хүүхэд, нярайн нарийн мэргэжлийн эмчийн **683 удаагийн дуудлагыг 51 эрүүл мэндийн байгууллагаас** хүлээн авч, **мэргэжил арга зүйн** зөвлөгөөг утсаар болон онлайн ашиглаж, зөвлөгөө өгч тусламж үйлчилгээ үзүүлэн, өвчтөний эмчилгээ, оношилгоо шинжилгээний зөвлөгөөг өгч чиглүүлж, шийдвэрлэсэн. | 100% |
| | | | Үзлэг, зөвөлгөөний тоо. | 700 | 750 | • ЭХЭМҮТ 2025 онд **1683 удаагийн эх, хүүхэд нярайн** дуудлагыг хүлээн авч, зөвлөгөө өгч, тусламж үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:<br>1. **Алсын** дуудлагаар хөдөө орон нутагт очиж үйлчилсэн тоо-20 /ЭБЭЭ-10, ХЭ-10/, нийт давхардсан тоогоор 21 их эмч үүрэг гүйцэтгэсэн.<br>2. **Хот доторх** дуудлагаар очиж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо-259 /ЭБЭЭ-27, ХЭ-232/<br>3. Аймаг, дүүргийн эмч нарт **Утсаар** зөвлөгөө өгсөн тоо-1206 /ЭБЭЭ-182, ХЭ-1024/ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4. Аймаг, дүүргийн эмч нарт **онлайнаар болон ZOOM-оор** зөвлөгөө өгсөн тоо-198 /ЭБЭЭ-27, ХЭ-171/ | |
| 5.8 | Эх, хүүхдийн чиглэлээр ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох нэвтрүүлэг бэлтгэж, түгээнэ. | - | Веб сайтаар нэвтрүүлсэн контент | 3 | 4 | • “Эхийн эндэгдлээс сэргийлэх” контент нийт 5 сайтаар түгээгдсэн.<br>• Нийгмийн сүлжээ, цахим орчинд “page” хуудас ашиглаж 70 орчим мэдээ мэдээлэл хүргэсэн.<br>1. 2025 оны 03 сарын 17 NTV мэдээ сайтаар “Эм, химийн бодисын хордолтоос сэргийлэх”,<br>2. 2025 оны 04 сарын 01-нд TIME.MN-сайтаар “Тээрхийн арьсны арчилгаа”-ны талаар,<br>3. 2025 оны 06 сарын 28-д Eguur New сайтаар “Наршилтаас сэргийлэх”,<br>4. Eagle News, ETVHD сайтуудаар “Дутуу төрөлтөөс сэргийлэх”,<br>5. NTV мэдээ сайтаар “Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх” талаар мэдээлэл, зөвлөмж өгсөн. | 100% |
| | | | Телевизээр нэвтрүүлсэн контент | | | • 2025 онд Eagle TV, C1 TV, МҮОНРТ, NTV – д 17 сэдвээр нийт 32 удаагийн мэдээ мэдээлэл хүргэсэн.<br>• 2025 оны 01 сарын 07-ны өдөр NTV, TV9 ТВ-үүдээр “Үжил, түүнээс сэргийлэх” талаар ЭБЭЭ-ийн зөвлөх эмч нар мэдээлэл өгсөн.<br>• 2025 оны 06-р сарын 22-нд ЭМЯ-аас санаачлан хэрэгжүүлсэн “Эх хүүхдийн сар” аяны хүрээнд тархвар судлаач эм MN25 ТВ-ээр Вакцинжуулалтын талаар эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл зөвлөгөө өгсөн.<br>• 2025 оны 06 сард ЭМЯ-аас санаачлан хэрэгжүүлсэн “Эх хүүхдийн сар” аяны хүрээнд MN25 ТВ-ээр ЭБЭЭ-ийн зөвлөх эмч “Жирэмсний үеийн хяналт, эрт илрүүлэг, түүний ач холбогдол”-ын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талаар эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл зөвлөгөө өгсөн.<br>• 2025 оны 09 сарын 25-нд UBS ТВ-ээр “Тархины саа өвчний үед хийгддэг мэдрэлийн ёзоор тайрах мэс засал”-ын талаар АНУ-ын Мэдрэлийн мэс заслын сангийн эмч нар болон төвийн ЕМЗТ-ийн эмч нар оролцон мэдээлэл хүргэсэн. | |
| **Зорилт-6. Эхийн эндэгдэл, эхийн ноцтой хүндрэлийн тандалт судалгааг үндэсний хэмжээнд хийнэ.** | | | | | | | |
| 6.1 | БСТ-2.2.1.1; 2.2.2.1. Эрүүл мэндийн байгууллагуудын эхийн эндэгдэл, эхийн ноцтой хүндрэл, амьгүй төрөлт, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тандалтын бүртгэл, тайлан мэдээнд дэмжлэгт хяналт, үнэлгээ хийнэ. | 15,0 сая төгрөг<br><br>(НҮБХАС) | Дэмжлэгт хяналт хийгдсэн аймгийн тоо, Тайлан | 8 | 11 | 2025 онд нийт 11 эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналт хийсэн.<br>• 2025 оны 9 дүгээр сард Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай, Ховд 4 аймагт дэмжлэгт хяналтаар явж мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан.<br>• Дэмжлэгт хяналтын дүгнэлт, зөвлөмжийг аймаг тус бүрт нь танилцуулж нэгдсэн дүгнэлт зөвлөмжийг лотусаар илгээсэн.<br>• "Эхийн болон перинаталь эндэгдлийн, тандалт хариу арга хэмжээ" сургалтаар Орхон, Сэлэнгэ, Дорноговь, Төв болон нийслэлийн 3 амаржих газар дэмжлэгт хяналтаар явсан.<br>• ЭМЯ, ЭХЭМҮТ хамтран 2025.06.06-ны өдрийн 11.00 цагт 2025 оны эхний 4 сарын эндэгдлийг хэлэлцэх “Нялхсын эндэгдлийн өнөөгийн байдал” сэдэвт цахим хурал хийгдсэн. Хуралд нийслэлийн амаржих газрууд, 21 аймгийн хүүхдийн тусламж хариуцсан мэргэжилтнүүд, шийдвэр гаргагч нар оролцсон.<br>• Хүүхэд, нярайн үндэсний баг байгуулагдсан. 8 сараас орон нутгаар удирдамжтай хяналт явна. Орон нутгийн эмч нар эндэгдлийн мэдээллийг сүүлийн 5 жилээр бэлтгэх чиглэл өгөгдсөн. Цаашид аймгуудад 5-6 чиглэлийн хүүхдийн тусламж үйлчилгээг хөгжүүлнэ. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Хүүхдийн эмнэлэгт нь ЭМС-ын 2022.05.06-ны өдрийн А/263 дугаар тушаал “Эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх тухай”-ын дагуу төвийн хэмжээнд эндсэн 0-5 насны хүүхдийн эндэлдлийг магадлан хэлэлцэх хурлыг улирал бүр хийж байна.<br>• 2025 оны эхний улирлын магадлан хэлэлцэх хурал 2025.06.12-ны өдөр хийгдэж эндэгдэл гарсан бүх тасгийн эрхлэгч эмч нар оролцсон. | |
| 6.2 | БСТ-2.2.1.2. Монгол улс дахь эхийн өвчлөл, эндэгдлийн байдалд бүрдэл судалгааг хийж, зөвлөмж хүргүүлнэ. | - | Судалгааны тайлан Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 1 | 1 | • "Монгол Улс дахь эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийн байдал, төрөлхийн хөгжлийн гажгийн тархварзүйн бүрдэл судалгаа-XI" дүгнэлт, зөвлөмжийг 2025 оны 6 дугаар сарын 30-нд захирлын 752 тоот албан бичгээр лотусаар илгээсэн. | 100% |
| 6.3 | БСТ-2.2.1.4. Улсын хэмжээний эхийн эндэгдлийг итгэмжит лавлагааг хийж, зөвлөмж хүргүүлнэ. | - | Зөвлөмж, хариу арга хэмжээний тоо | 1 | 1 | • “Эх яагаад эндэв, 2020-2023” итгэмжит лавлагаа судалгаа хийгдэж дуусаад, дүгнэлт, зөвлөмжийг Ерөнхий захирлын 2025 оны 03 сарын 26-ны өдрийн 247 албан тоотоор эрүүл мэндийн байгууллагуудад илгээсэн. | 100% |
| 6.4 | БСТ-2.2.2.2. Монгол улс дахь хүүхдийн өвчлөл, эндэгдлийн байдал, төрөлхийн хөгжлийн гажгийн тархварзүйн бүрдэл судалгааг хийж, зөвлөмж хүргүүлнэ. | 15,0 сая төгрөг<br><br>(НҮБХАС) | Судалгааны тайлан Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 1 | 1 | • "Монгол Улс дахь эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийн байдал, төрөлхийн хөгжлийн гажгийн тархварзүйн бүрдэл судалгаа - XI" дүгнэлт, зөвлөмжийг 2025 оны 6 дугаар сарын 30-нд захирлын 752 тоот албан бичгээр лотусаар илгээсэн. | 100% |
| 6.5 | БСТ-2.2.2.3. Улсын хэмжээний 5 хүртэлх насны хүүхдийн ба эхийн эндэгдэл, эхийн ноцтой хүндрэл, амьгүй төрөлтийн тоон | 3,5 сая төгрөг<br><br>(НҮБХАС) | Хяналтын самбарын тоо | 1 | 1 | • Хянах самбар (Dashboard) 9 үзүүлэлтээр Амаржсан эх, амьд төрөлт, амьгүй төрөлт, эхийн эндэгдэл, эхийн ноцтой хүндрэл, нярайн эндэгдэл, нялхсын эндэгдэл, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тоо, түвшинг сар, улирал тус бүрээр мэдээллийн сан үүсгэж хянах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн хяналтын самбар боловсруулна. | | | | | самбарт хөгжүүлэлт хийж тогтмолжуулсан. | |
| 6.6 | БСТ-1.1.3.6. Эмнэлэгт суурилсан хүүхдийн хавдрын өвчлөл, нас баралтыг нэгдсэн тогтолцоогоор бүртгэнэ. | - | Бүртгэлийн журам | 1 | 1 | • 2025 оны эхний 10 сарын байдлаар шинээр оношлогдсон хорт хавдрын 71 тохиолдолын АМ-5 маягтыг ЭМС-ын А/611 тоот тушаалын дагуу Н info-3.0 програмд бүртгэн ЭМХТ болон ХСҮТ-д цахим хаягаар илгээсэн.<br>• Хүүхдийн хорт хавдрын тусламж үйлчилгээний **Эмнэлэгт суурилсан бүртгэлийн гарын авлагыг хэвлүүлж хавдрын бүртгэлийн exsel файлаар нийт 51 хүүхдийг бүртгэсэн** | 100% |
| **Зорилт – 7. Байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагаа хангаж, стандарт, удирдамж, зааврыг баримтлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулна.** | | | | | | | |
| 7.1 | БСТ-2.3.1.1. ЭХЭМҮТ-ийн “Чанарын хөгжлийн хөтөлбөр, 2024-2027”-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөгөөний биелэлтийн хувь (2025 оны төлөвлөгөөний биелэлт) | 96% | 97% | • “**ЭХЭМҮТ-ийн тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр, 2024-2027**”-ийг 2024.02.19-ний өдөр хугацаанд нь батлуулсан.<br>• “**ЭХЭМҮТ-ийн тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр, 2024-2027**”- ийн хэрэгжилтийг үнэлэх хугацаа нь хөтөлбөрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ” хэсэгт заасны дагуу 2026 оны 1-р сард үнлэнэ.<br>• 2025 оны 11-р сарын байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 98%-тай байна. | 100% |
| 7.2 | БСТ-2.3.1.2. Олон улсын магадлан итгэмжлэх үйл ажиллагаа эхлүүлнэ. | - | Магадлан итгэмжлэгдсэн байна. | 0 | 1 | • Олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагаа эхлүүлэх 2025 оны ажлын төлөвлөгөөнд тодотгол хийж, Процессын багийн нөхцөл байдлын шинжилгээний үр дүнд гаргаж тавьсан 23 ажлыг биелүүлэхээр Ерөнхий захирлаар батлуулахаар ЭМТҮЧАБА-ны баг бүрэлдхүүн хэлэлцүүлэн бэлэн болгосон байгаа. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Төвийн нөхцөл байдлын үнэлгээний 23 асуудлыг Мобикомын баг 2025 оны 4 дүгээр сард төвийн Захирлын зөвлөл, бүх тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарт танилцуулсан.<br>• Эдгээрээс үндэслэн тус төвийг Олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагааг эхлүүлэх 2025 оны ажлын төлөвлөгөөнд тодотгол хийж, Ерөнхий захирлаар 2025 оны 7 дугаар сард батлуулахаар бэлэн болсон.<br>• **Олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх ажлын хүрээнд “Процессыг удирдаж чанарыг сайжруулах нь” сэдэвт өдөрлөгийн шийдвэрээр цаашид 2027 оны дуустал эмнэлгийн тусламж үйлчилгээний процессыг үргэлжлүүлэн дагаж судлахаар болсон.** Ийнхүү олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагааны 2025 оны ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 онд Хүүхдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний дараах 4 үйл явцад процессыг дагаж судалсан. Үүнд:<br>1. **ЯТТ-т үйлчлүүлэгч ирэх процесс:** Дүгнэлт: Яаралтай тусламжийн тасагт эрэмбэлэн ангилалт хийгдэхгүй, туслах сувилагч, сувилагч нарын эрэмбэлэн ангилалтын мэдлэг, дадал хангалтгүй, үйлчлүүлэгчид эрэмбийн тухай тайлбарладаггүй тул гомдол гарах нөхцөл бүрдэж байсан.<br>2. **Хүүхдийн амбулаторийн цаг товлол:** ХЗП-ийн зарим зарим кабинетуудад үзлэгийн хүлээгдэл ихтэй, товлолт үзлэгийн цаг авсан зарим үйлчлүүлэгчид цагтаа | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ирдэггүй, товлолт үзлэгийн 50-70% хийгдэж байсан.<br>3. **Үйчлүүлэгчийг дэмжих тасгийн Call center үйлчилгээ:** Дүгнэлт: ҮДТ-ийн Call center төвд 2 ажилтан ажиллаж 130 минутанд 145 дуудлага хүлээн авснаас ХЭ-ийн дуудлага 66% байна. 1 дуудлагад дунджаар 1.8 минутын турш хариулт өгч байсан. Иймээс тус төвд хандан товлолт цаг авах үйлчлүүлэгч бүрийн утсбг авч чадахгүй тул 60-70%-д хариулт өгч бусад үйлчлүүлэгчдээс гомдол гарах нөхцөл бүрддэг.<br>4. Хүүхдийн амбулаторийн цахим бүртгэл: ажилтныг дагаж цаг товлох процессийг үнэлсэн**. Дүгнэлт:** ХЗП-ийн хэвлэгч машин тухайн өдөр 613 дугаар хэвлэсэн. 3 ажилтан нийтдээ дунджаар 700 гаруй хүнд үйлчилсэн. Нэг үйлчлүүлэгчид дунджаар 1.6 минут үйлчилгээ үзүүлсэн. Цаг товлохдоо нярайг дугаарлуулахгүй авдаг. Үйлчлүүлэгчийн өөрсдийн хайхрамжгүй байдлаас болж цахим бүртгэлийн ажилтнуудад нэмэлт ачаалал их ирж байсан. | |
| 7.3 | БСТ-1.1.3.1; 1.1.3.2. Хүүхдийн хавдрын оношилгоо, эмчилгээний зааврыг шинэчлэн, нэвтрүүлнэ. | - | Поликлиникийн нөхцөлд хянах, эмчлэх шинэчилсэн зааврын тоо | 6 | 6 | • Нейробластома, germ cell tumor, гепатобластома, лангерганс эсийн гистиоцитоз, остеосаркома, юнга саркома заавар боловсруулж байна. | 50% |
| | | | Оношилгоо эмчилгээний шинэчилсэн зааврын тоо | 6 | 6 | • Үүдэл эс шилжүүлэх заавар боловсруулсан. Төвийокн эрдмийн зөвлөл болон яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлсэн.<br>• ЭМС-ын тушаалаар батлуулахаар ЭМЯ-ны ЭТБХГ-т хүргүүлсэн. | 20% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.4 | БСТ-2.3.1.3. Лабораторийн шинжилгээнүүдийн гадаад хяналтын үнэлгээг нэмэгдүүлнэ. | - | Лабораторийн гадаад хяналтын үнэлгээ | 90% | 91% | • Чанарын гадаад хяналтын ОУ-ын гадаад үнэлгээнд Австралын гадаад хяналтанд биохимийн шинжилгээний төрлийг нэмсэн. Мөн шээсний шинжилгээгээр орж гэрчилгээг авсан.<br>• 2025 онд гадаад хяналтанд 6 чиглэлээр 8 удаа хамрагдсан. Гадаад хяналтын үнэлгээ 95,43% өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,13%-иар өссөн сайн үзүүлэлттэй байна.<br>• Дараах чиглэлээр гадаад хяналтанд хамрагдсан. Үүнд:<br>1. Цус судлал чиглэлээр 3 удаа,<br>2. Цусны хувийн тохироо 1 удаа<br>3. Шээсний ерөнхий шинжилгээ 1 удаа<br>4. Нян судлалын шинжилгээ 1 удаа<br>5. Биохими 1 удаа<br>6. Сүрьеэ 1 удаа тус тус хамрагдсан байна. | 100% |
| 7.5 | БСТ-2.3.1.4. Сувилахуйн тусламж, үйлчилгээнд чанар сайжруулах шинэ аргыг нэвтрүүлнэ. | - | Шинээр нэвтрүүлсэн аргын тоо | 6 | 6 | • “Сувилахуйн инноваци-2025” аяныг 2025 оны 3-р сарын 30-с 2025 оны 4-р сарын 29-ны өдрийг хүртэлх 1 сарын хугацаанд аяныг зохион байгуулахад 17 тасаг сувилахуйн тусламж үйлчилгээнд **28 шинэ аргыг нэвтрүүлсэн.**<br>• Тусламж үйлчилгээнд дараах 3 шинэ аргыг нэвтрүүлсэн. Үүнд:<br>1. Дусал эмчилгээнд 3 замт крантыг дуслын шахуурганд ашиглах,<br>2. Амьсгалын аппаратны (humidifier) чийгшүүлэх саванд нэрмэл усыг хийх арга,<br>3. Детектор тогтоогчтой сандал,<br>• Сувилахуйн тусламж үйлчилгээний 4 заавар шинээр боловсруулж хянуулж байна. Үүнд:<br>1. Менингит өвчний үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний заавар<br>2. Хүүхдийн нүдний зовхины оёдол авах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. Хүүхдийн харааны чадал шалгах<br>4. Нүдний нулимсны сувгийн массаж хийх заавар | |
| 7.6 | БСТ-2.3.2.1. Химийн эм, бэлдмэлийн найрлагын хэсгийн үйл ажиллагааг стандартад нийцүүлнэ. | - | Стандартад нийцсэн найрлагын хэсэг | 2 | 2 | • Эм найрлагын хэсгийг 2 хуваан хүүхдийн хорт хавдрын химийн тариа найруулах хэсэг болон энгийн эмийн найрлагын хэсэг болгон үйл ажиллагааг өргөжүүлсэн байна.<br>• Химийн эм тариа найруулах хэсгийг стандартад нийцүүлэн тохижуулах ажлыг гүйцэтгэсэн.<br>• Эрүүл зүйн нян судлалын арчдасны шинжилгээ 4 удаа хийлгэж ургалтгүй гарсан.<br>• Хүүхдийн хорт хавдрын төслийн хүрээнд химийн найрлагын хэсэгт 12 камерын суурилуулаад байна.<br>• Найрлагын хэсгийг хувааснаар хорт хавдартай хүүхдүүдийн эмийн эмчилгээ, цитотоксик эмийн аюулгүй байдал хангагдаж байна. Мөн химийн эмчилгээний эмийг тасагт найруулахгүй болсноор сувилагчдын ажлийн ачаалал багасаж, цитотоксик эмэнд эмч, сувилагч, эмчлүүлэгч түүний асран хамгаалагчид өртөх эрсдэл багассан.<br>• Тайлант хугацаанд хүүхдийн хорт хавдрын химийн тариаг давхардсан тоогоор 2402 хүүхдэд 3020 удаагийн тариа, 3 нэр төрлийн уух эмийн хэлбэрийг 1672 ширхгийг хувааж тугнан найруулан бэлтгэн ЦЭХСТ-т олгосон байна. | 100% |
| 7.7 | БСТ-2.3.2.3. Нянгийн тэсвэржилтийн хяналт, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээний | - | Хэрэгжилтийн хувь | 92% | 93% | • Антибиотикийн дэд хорооны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 8 ажлыг хийхээр төлөвлөн Эмийн эмчилгээг зохицуулах хорооны даргаар батлуулан ажиллаа. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | | | | | • Төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.<br>1. Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө, ЭЭХХЗГ-ийн даргын 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А/28 тоот тушаалын дагуу төлөвлөгөө боловсруулан ажиллаж төлөвлөгөөний биелэлт 95%-тай байна.<br>2. Нян судлалын лабораторид 20675 өсгөврийн шинжилгээ хийгдсэн. Үүнээс нянгийн ургалттай 2987 (14,4%) сорьцны шинжилгээнд антибиотик мэдрэг чанарыг тодорхойлсон.<br>3. Бичил биетний тэсвэржилтийн эсрэг мэдлэг, хандлагыг дээшлүүлэх дэлхийн долоо хоног”-ийг 2025 оны 11 дүгээр сарын 18–24-ний өдрүүдэд “Ирээдүйнхээ аюулгүй байдлын төлөө өнөөдрөө хамгаалж, яг одоо хэрэгжүүлж эхлэе” уриан дор төлөвлөгөө гарган зохион байгуулж ажиллаа.<br>4. Эмийн зохистой хэрэглээ, антибиотик эмийн сорил тавих, шингэрүүлэлт хийх, эмийн сонголт хийх, цахим жор бичилт, халдварын сэргийлэлт хяналтын талаар 33 тасагт 62 удаагийн сургалтыг зохион байгуулж 242 сувилагч нарыг хамруулан зохион байгуулсан.<br>5. Төвийн хэмжээнд эмч нарын яриан дээр 4 удаагийн сургалт хийж 200 гаруй эмч хамрагдсан. | |
| 7.8 | БСТ-2.3.2.4. Эмнэлгийн хүчилтөрөгч хадгалах байр, дамжуулах | - | Стандарт хангасан хүчилтөрөгчийн шугам (%) | 50% | 70% | Тайлант хугацаанд эмнэлгийн хүчилтөрөгчийн хадгалах байр, дамжуулах шугамын стандартыг хангахад дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шугамын стандартыг хангана | | | | | • ЭБЭЭ-ийн хүчилтөрөгч хэрэглэдэг эмчилгээ үйлчилгээний 13 тасгийн хүчилтөрөгчийн ханын системийг шинэчлэн татсанаар ЭБЭЭ 100% шинэ хүчилтөрөгчийн ханын системээр хангагдсан байна.<br>• ХЭ-ийн хүчилтөрөгч хэрэглэдэг эмчилгээ үйлчилгээний 21 тасгаас 10 тасгийн хүчилтөрөгчийн ханын системийг шинэчлэн татсанаар ХЭ 47% хангагдсан байна.<br>• Төвийн хэмжээнд тасаг нэгжүүдийн 73,5% нь стандарт хангасан хүчилтөрөгчийн шугамтай боллоо.<br>• Хүчилтөрөгчийн 2 үйлдвэрийн гадна хэсэгт тэмдэг тэмдэглэгээ болон галын сарааг шинээр хийж тохижуууллаа. Үйлдвэр дээр гарах эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах таних тэмдэглэгээнүүдийг хийгээд байна.<br>1. Галын сараалжин хашаа - 2 ширхэг<br>2. Галын самбар - 4 ширхэг<br>3. Аюулгүйн орчин - 3 ширхэг<br>4. Гадны хүн орохыг хориглосон тэмдэг - 5 ширхэг<br>5. Даралтат сав - 3 ширхэг<br>6. Тэсрэх аюултай - 5 ширхэг<br>7. Гал гаргахыг хориглоно - 5 ширхэг<br>8. Зогсохыг хориглоно - 3 ширхэг<br>9. Ачилтын тэмдэг - 3 ширхэг тус тус хэвлэн гаргасан байна.<br>• Энэхүү тэмдэглэгээнүүд нь гадна байрлуулах боломжтой зэвэрдэггүй бат, бөх материалаар хийгдсэн байна. | |
| 7.9 | БСТ-2.3.2.5. Эмчилгээний хоол, үйлдвэрлэлийн технологийн урсгалын стандартыг хангах | - | Хоол үйлдвэрлэл үйлчилгээний технологийн урсгалын үнэлгээ | 94% | 96% | • ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн баг Эмчилгээний хоол судлалын тасгийн үйлдвэрлэл үйлчилгээний хэсэгт нөхцөл байдлын үнэлгээг хийсэн. 85%-тай үнэлэгдсэн. | 89% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Хүүхдийн эмнэлгийн хоол үйлдвэрлэлийн хэсгийн мах бэлтгэл, ногоо бэлтгэл, хоол үйлдвэрлэлийн цехэд стандарт хангасан хоол үйлдвэрлэлийн урсгалыг бий болгон тохижуулсан.<br>• Тайлант хугацаанд эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн засвар үйлчилгээтэй холбоотойгоор эх, барихын хэсгийг хүүхдийн эмнэлгийн хоол, үйлдвэрлэлийн хэсэг рүү түр шилжүүлэх зохицуулалтыг хийж, стандарт шаардлагыг хангaн ажиллаж байна. | |
| 7.10 | БСТ-2.3.3.1. Тасаг, нэгжүүдийн халдвар хамгааллын дэглэмийн байдал, эмнэлгээс шалтгаалсан халдвараас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | - | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | • Төвийн тасаг нэгжүүдэд халдвар судлаач эмч нар нийт 539 удаагийн хяналтыг хийж, шинэ болон сэргэж буй халдварт өвчний үед баримтлах дэглэм, барилгын их засварын үеийн зохицуулалт, тоосжилт үүссэн үед анхаарах зүйлс, хог хаягдлын ангилал цуглуулалт, шинжилгээт хяналтуудыг хийж нийт 68 зөвлөмжийг хүргүүлсэн. Тасаг нэгжид хийсэн хяналтын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.8%-р өссөн үзүүлэлттэй байна.<br>• Мөн сувилахуй болон чанарын албатай хамтарч 33 тасагт хяналтыг хийж илэрсэн үл нийцлүүдийг арилгах зөвлөмжийг өгч, эргэн хяналтыг хийж ажилласан. Хамтарсан багаар удирдамжтай хийсэн хяналтанд хамрагдсан тасгийн тоо өмнөх оны мөн үеэс 12 %-р өссөн байна.<br>• Энэ онд гадаад хяналтанд 2 удаа хамрагдсан бөгөөд хангалттай үнэлэгдсэн. ЭМЯ-ны салбарын хяналтын газраас “Улаанбурхан өвчний үеийн бэлэн байдал”-н үнэлгээгээр хангалттай, НЭМГ-н 2025 оны төлөвлөгөөт хяналт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгалтын хүрээнд “Бага эрсдэлтэй” үнэлгээ авсан.<br>• Тасаг нэгжүүдийн орчны эд зүйлсээс 213 удаа нийт 3354 цэгээс эрүүл зүйн нян судалын шинжилгээг авахд 9.1 %-д буюу 318 цэгт нянгийн бохирдол илэрсэн нь өмнөх оны мөн үеэс нийт авсан арчдас шинжилгээний тоо 3.0 %-иар өссөн байна.<br>• 2025 оны эхний 10 сард мэс нярай болон заслын шархны халдварын сэжигтэй 48 тохиолдлыг бүртгэн 23 тохиолдлыг ХӨСҮТ-д мэдээлсэн. Мэдээлэгдсэн халдварын сэжигтэй тохиолдлууд нь нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.7 %-р өссөн үзүүлэлттэй байна.<br>• 2025 оны эхний 10 сард амьсгалын аппараттай 1185 хүн 1164 өдөр байснаас АА-тай холбоотой халдварын тохиолдол бүртгэгдээгүй. 2662 шээлгүүр, 7301 судасны гуурс, төвийн венийг гуурс 782 хүн, 630 өдөр тавигдснаас ЭТҮХХ илрээгүй байна. ЭЭСТ-т судасны гуурстай холбоотой халдварын шинж тэмдэг бүхий 1 тохиолдлыг бүртгэн судалгааг хийж, үгүйсгэсэн байна.<br>• 2025 оны эхний 10 сард оношлогдож шилжсэн цочмог халдварын батлагдсан- 88 тохиолдлыг (улаанбурхан- 79, салхинцэцэг-2, сүрьеэ-5, цусан суулга-1, Пара вирус-1,) ХӨСҮТ-д шилжүүлж голомтын арга хэмжээг авч, судалгааг хийж ажилласан бөгөөд эмнэлэгт дотоод халдвар байдлаар тархаагаагүй.<br>• Улаанбурхан өвчний батлагдсан тохиолдлуудтай ойрын хавьтал болсон эмч, эмнэлгийн ажилтан, дадлагажигч оюутан, эмч, резидент болон сахиуруудад хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэн голомтын тандалт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судалгааг хийж нийт 205 хүнийг УУ-ын вакцинд хамруулснаас ажилчин 114 ажилтан, 43 резидент эмч, 48 сахиур байна. | |
| 7.11 | БСТ-2.3.3.2. Ариутгал, халдваргүйтгэл, эмнэлгийн гаралтай тусгай хог хаягдлын талаарх тушаал, тогтоолыг хэрэгжүүлнэ. | 61,3 сая.төг | Тушаал, тогтоолын хэрэгжилтийн хувь | 97% | 98% | • 2025 оны эхний 10 сард ариутгалын хэсгүүдэд тасаг нэгжүүдээс тусламж үйлчилгээнд давтан хэрэглэгдэх багаж хэрэгсэл 498,306 ширхэг ирсэнийг хүлээн авч угааж, цэвэрлэн халдваргүйжүүлэн угаалгын чанарт 12 удаагийн сорилыг тавьж үзэхэд үл нийцэл гараагүй. Угааж халдваргүйжүүлэн багаж хэрэгслийг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзэхэд 3.0 % буюу 14740 ш-р өссөн байна.<br>• Халдваргүйжүүлэн савласан 56,828 бикс, боодол багаж хэрэгслийг ариутган тасаг нэгжүүдэд олгон ажилласан бөгөөд ариутгасан багаж, хэрэгслийн тоо өмнөх үеийн мөн үетэй харьцуулахад 8.5%-р өссөн үзүүлэлттэй байна.<br>• Багаж хэрэгслийн ариутгалын үйл ажиллагаанд гадна дотор хяналтын индикаторуудыг тогтмол хийн ажилласан бөгөөд Дотор хяналтын индикатороор хийсэн хяналт 5338 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56.9 %-р өссөн байна.<br>• Ариутгалын аппаратуудыг 2,299 цаг ажиллуулсан нь өмнөх онтой харьцуулахад 14.0 %-р өссөн байна.<br>• Тасгийн урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийн хэсэгт нийт 31967 ш хөнжил, гудас матрацийг хүлээн авч халдваргүйжүүлэн олгосон. Оношлогдож шилжсэн болон тусгаарлагдан эмчлэгдсэн /улаанбурхан/ цочмог халдварын голомтоос 935 ш, хөнжил, гудас матрацийг авч халдваргүйтгэлийг хийж өгсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад урьдчилан сэргийлэх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | халдваргүйтгэл 32.9 %-р ,голомтын халдваргүйтгэл хийсэн зөөлөн эдлэл 52.9%-р тус тус өссөн байна.<br>• Тасаг нэгжүүдийн өрөө тасалгаа, нийтийн эзэмшлийн талбайд урьдчилсан сэргийлэх халдваргүйтгэлийг 581,187 кв.м талбайд хийсэн нь өмнөх оны мөн үеэс 16.6%-р, голомтын халдваргүйтгэлийг 54,040 кв.м талбайд хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.<br>• Энэ оны эхний 10 сард угаалгын хэсэгт нийт 397,058 ш зөөлөн эдлэл, ажлын хувцас хэрэгслийг хүлээн авч угааж, цэвэрлэн индүүдэж тасаг нэгжүүдэд олгосон бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 126,262ш буюу 31.7 %-р буурсан байна. Угаалгын хэсэгт зөөлөн эдлэл угаах тоног төхөөрөмж / 1 том, 1 жижиг машин ажиллаж байгаа /-тэй холбоотой тоон үзүүлэлт буурсан байна.<br>• Энэ оны эхний 10 сард нийт 67.03 тн халдвартай хог хаягдлыг цуглуулан гэрээт газарт 258 удаа хүлээлгэн өгч бүртгэл тэмдэглэлийг хөтөлсөн. Тусламж үйлчилгээнээс гарсан аюултай хог хаягдлын хэмжээ өмнөх оны /67.6 тн/ мөн үетэй харьцуулан үзэхэд 0.8%-р /0.572тн/ буурсан үзүүлэлттэй байна.<br>• 2025 оны эхний 10 сард эмгэг судлалын хэсэгт нийт 366 эндэгдэл хөргөгчинд хадгалагдаж 232 тохиолдол задлан шинжилгээнд орсон. Өмнөх оны мөн үеэс 11 тохиолдоор өссөн үзүүлэлттэй байна. | |
| 7.12 | БСТ-2.3.3.3. Тусламж, үйлчилгээнд давтан хэрэглэх багаж хэрэгслийг угаах автомат угаалгын | - | Нэмэгдүүлсэн багаж, тоног төхөөрөмжийн тоо | 6 | 6 | • Тусламж үйлчилгээнд давтан хэрэглэх эмнэлгийн багаж хэрэгсэл угаах автомат угаалгын машины судалгааг гарган байгууллагын тендерийн хороонд үзүүлэлтийн хамт хүргүүлсэн. | 60% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | машин, төхөөрөмжийг шинэчлэнэ. | | | | | | |
| 7.13 | БСТ-2.3.3.4. Зөөлөн эдлэлийг халдваргүйтгэх аппарат, тоног төхөөрөмжийг шинэчлэх | - | Шинэчлэгдсэн тоног төхөөрөмжийн тоо, нэр төрөл | 4 | 5 | • Тасгийн зөөлөн эдлэлийн халдваргүйтгэлийн хэсэгт суурин 2 аппарат хэвийн ажиллаж байна.<br>• Том матраци аппаратанд багтдаггүй тул жижиг оврын зөөврийн халдваргүйтгэлийн аппаратыг судлан үзүүлэлтүүдийг гарган тендерийн хороонд хүргүүлсэн. Мөн ЗӨСҮТ-с 2022 онд нийлүүлсэн жижиг шүршигчийг ашиглаж байна. | 60% |
| 7.14 | БСТ-2.3.3.5. Өндөр даралтат аппарат, тоног төхөөрөмжийн ариутгал, халдваргүйтэлийг нэмэгдүүлэх | - | Багаж, тоног төхөөрөмжийн тоо | 5 | 6 | • 2025 оны эхний 10 сард ариутгалын хэсгүүдэд тасаг нэгжүүдээс тусламж үйлчилгээнд давтан хэрэглэгдэх багаж хэрэгсэл 498,306 ширхэг ирсэнийг хүлээн авч угааж, цэвэрлэн халдваргүйжүүлэн угаалгын чанарт 12 удаагийн сорилыг тавьж үзэхэд үл нийцэл гараагүй. Угааж халдваргүйжүүлэн багаж хэрэгслийг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзэхэд 3.0 % буюу 14,740ш-р өссөн байна.<br>• Халдваргүйжүүлэн савласан 56,828 бикс, боодол багаж хэрэгслийг ариутган тасаг нэгжүүдэд олгон ажилласан бөгөөд ариутгасан багаж, хэрэгслийн тоо өмнөх үеийн мөн үетэй харьцуулахад 8.5 %-р өссөн үзүүлэлттэй байна.<br>• Багаж хэрэгслийн ариутгалын үйл ажиллагаанд гадна дотор хяналтын индикаторуудыг тогтмол хийн ажилласан бөгөөд Дотор хяналтын индикатороор хийсэн хяналт 5,338 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56.9 %-р өссөн байна.<br>• Тайлант хугацаанд тусламж үйлчилгээнд дэвтэн хэрэглэх багаж хэрэгслийг угааж цэвэрлэх бодис уусмал 15 нэр, төрөл, арьс салст халдваргүйжүүлэх бодис 2 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэр төрөл, эд эс бэхжүүлэх уусмал 1 нэр төрөл, угааж цэвэрлэх сойз 5 төрөл, багаж хэрэгслийн цэвэрлэгээний чанар шалгах хяналтын сорил 5 төрөл,шалгаж цэвэрлэсэн багаж хэрэгслийн зэвийг арилгах тослох арчлах зүйлс 6 төрөл,боож савлах уут сав 4 нэр төрөл, 15 хэмжээтэй,ариутгалын чанар шалгах гадна, дотор талын болон нянгийн өсгөвөртэй хяналтын индикаторууд 8 төрлөөр нийт 560 ш хангалтыг хийлгүүлэн ажилласан.<br>• Тайлант хугацаанд сантехник, ус, цахилгаан халаалтын -42, эмнэлгийн тоног төхөөрмжийн-42, холбоо, интернет шугам, сүлжээ-5, мужаан барилгачин-10, гаднаас эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн инженерийн 5 нийт 105 дуудлагыг холбогдох чиглэлээр өгч засвар үйлчилгээг хийлгэх үл нийцэлгүй ажилласан. Хэвийн үйл ажиллагааг явуулахад анхаарч ажилласан дуудлагын тоо өмнөх онтой харьцуулахад 45.2%-р өссөн үзүүлэлттэй байна.<br>• Эмгэг судлалын хэсэгт шинээр 1 кондейшин, 2 мотор авч эмгэг судлалын хэсгийн хөргөгчний өрөөнүүдэд байрлуулсан.<br>• Угаалгын хэсэгт халуунаар үлээгч 2 кондейшин шинээр суурилуулсан. | |
| **Зорилт–8. Судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулж, хүний нөөцийг чадавхжуулна.** | | | | | | | |
| 8.1 | БСТ-3.3.1. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 141,5 сая.төг (НҮБХАС) 109,3 сая.төг (ЭМДС) | Хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо | 12 | 12 | **Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр- 10**<br>1. БНСУ-ын Самсунгийн ЭМТ-тэй хамтын ажиллагааны хүрээнд няхайн зүрхний нээлттэй мэс заслыг нэвтрүүлэх хөтөлбөрийн дагуу 16 эмч, сувилагчийг бэлтгэсэн. | 83% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. ЭХЭМҮТ-ЭМХТ-БНХАУ-ын Фуданы эмнэлэгтэй байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд 7 эмч сувилагчийг бэлтгэсэн.<br>3. АНУ-ын “Neurosurgery Outreach Foundation“ сантай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд мэдрэлийн эмч нарт сургалт явуулсан. шаардлагатай хүүхдүүдэд мэс засал эмчилгээ хийж хамтран ажилласан.<br>4. ДЭМБ-тай Эмийн платформын төсөл хэрэгжүүлж БНСУ-д 8 хүн сургах, хорт хавдрын эм хүлээн авах, тоног төхөөрөмжөөр хангах үйл ажиллагаа хийгдсэн.<br>5. Зүрхний нээлттэй мэс заслыг ЭХЭМҮТ-д нутагшуулах төслийн хүрээнд Штрасбург-Люксембургийн баг хамтран мэс засал хийж хамтран ажилласан.<br>6. Орбис төслийн хүрээнд АНУ-ын<br>7. ЭНМЗ<br>8. Зүрх хамгаалах төсөл<br>9. TIKA<br>10. НҮБ-ын ХАС-ийн төслийн хүрээнд ЖСАХ-ийн цахим бүртгэл, сургалт хөтөлбөрийн дагуу хийгдэж байна | |
| 8.2 | БСТ-3.3.2. Эрдэм шинжилгээний төслийн тоог нэмэгдүүлнэ. | 24,5 сая.төг (НҮБХАС) | Эрдэм шинжилгээ, судалгааны төслийн тоо | 12 | 12 | **Төслийн тоо- 11**<br>1. Өсвөр үеийн охидын жирэмслэлт, төрөлтийг судлах нь" судалгааны ажлыг НҮБ, ХАС-тай хамтран гүйцэтгэж, судалгааны арга, аргачлалыг батлуулсан.<br>2. Эх, хүүхдийин өргөн хэрэглээний хүнсний уургийн чанарыг судлах судалгааг Олон улсын цөмийн энергийн агентлаг, Монгол улсын цөмийн энергийн комисстой хамтран хэрэгжүүлж байна.<br>3. Хүүхдийн хорт хавдрын амьдрах хувийг тооцох нь судалгааны ажлын хүрээнд сүүлийн 10 жилд хавдар оношлогдсон | 92% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдийн амьдарсан хувийг тооцох ажлыг гүйцэтгэж байна.<br>4. Бернийн их сургуультай хамтран Монголд Швейцарын хүүхдийн амьсгалын замын когорт судалгааг нэвтрүүлэн хүүхдийн астма-(гуурсан хоолойн багтраа) өвчний оношилгоо, эмчилгээний тулгамдсан асуудлыг судлах нь төслийн арга, аргачлалыг эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.<br>5. Хүүхдийн тархины саагийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийг эмнэлзүй ба тавилантай холбон судлах нь төслийн судалгааны ажлын арга, аргачлалыг боловсруулж, эрдмийн зөвлөлийн хуралаар батлуулахаар бэлтгэж байна.<br>6. Хэрэхийн гаралтай зүрхний эмгэгийн эрсдэлт хүчин зүйлийн судалгаа арга, аргачлалыг батлуулж, ЭМЯ-аас ёс зүйн зөвшөөрөл авч судалгааны ажил эхэлсэн.<br>7. Хүүхдийн эрт илрүүлгийн их өгөгдөлд суурилсан судалгаа боловсруулалтын ажил эхэлсэн.<br>8. Монгол Улсад дутуу нярайн ретинопатийн эрсдэлт хүчин зүйл, эмнэлзүй, оношилгоо ба эмчилгээний үр дүн (Хиймэл оюун ухаанд суурилсан ДНР-ийг илрүүлэх)” судалгааны төсөл арга, аргачлалыг батлуулж, ЭМЯ-аас ёс зүйн зөвшөөрөл авч судалгааны ажил эхэлсэн.<br>9. ”Эх барихын үжлийн эмнэлзүйн аудитын үр дүн” боловсруулалтын ажил хийгдэж байна.<br>10. Инвазив бус аргаар ургийн гажгийг дижитал полимеразийн гинжин урвал (ПГУ) ашиглан илрүүлэх нь ШУТС-ийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санхүүжилттэй ЭМЯ-ны захиалгат төслийн багт ажиллаж байна.<br>11. Khaliunaa T, Gerelsuren, Nomuun, Dolgion D, Jamiyan P, Tuul B, Sansar G, Altantsetseg B, Gantulga D, Development and Clinical Implementation of a Digital PCR-Based Method for Non-Invasive Prenatal Test of Trisomy 21 in Mongolia, Proceedings of the International Biological Conference in Mongolia 2025 (IBCM 2025) (pp. 187–198). Atlantis Press-д судалгааны өгүүлэл хэвлүүлсэн. | |
| 8.3 | БСТ-3.3.3. Эрдэм шинжилгээний ажлын чанарыг сайжруулна. | - | Олон улсын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо | 8 | 9 | • **Олон улсын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо – 8**<br>1. Banzar, M., Jamsranjav, E., Janlav, M., & Lundeg, G. (2024). Invasive Hemodynamic Monitoring and Arterial Blood Gas Exchange During Spinal vs General Anesthesia for Cesarean Delivery in Mongolian Parturient. Central Asian Journal of Medical Sciences, 10(4), 130–139. https://doi.org/10.24079/cajms.2024.04.001<br>2. Jargaldavaa, E., Gongorjav, A., Badral, B., & Lkhamsuren, K. (2024). Surgical Treatment of Velopharyngeal Insufficiency Following Primary Palatoplasty. Central Asian Journal of Medical Sciences, 10(4), 149–157. https://doi.org/10.24079/cajms.2024.04.003<br>3. Buyandelger B., Yerkebulan M., Sarnai Ts., Nasantogtokh E., Khurelbaatar N., Davaalkham D., Validation of the Mongolian version of the multifactor leadership questionnaire (mlq) in clinical leaders of hospital, Central Asian Journal of Medical Sciences, 11(1) | 89% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4. Banzar,M.; Erdenebileg,N.; Surjavkhlan,T.; Jamsaranjav,E.; Janlav,M.; Lundeg,G. A Comparative Study of Brain Injury Biomarker S100β During General and Spinal Anesthesia for Caesarean Delivery: A Prospective Study. Journal of medicina, MDPI 2025051321.<br>5. Enkhmaa, D., Enkhtaivan, O., Batsuuri, B., Erdenebileg, N., Baatar, T., Bayanbileg, S., Shirchinjav, A. (2025). Trends in Cesarean Section in a Tertiary Referral Hospital: Time-Series Analysis. *Central Asian Journal of Medical Sciences*, *11*(2), 69–83.<br>6. Buyandelger Boldbaatar, Yerkebulan Mukhtar , Sarnai Tsagaankhuu, Erdenebileg Nasantogtokh , Khurelbaatar Nyamdavaa, Davaalkham Dambadarjaa. Leadership Styles and Its Outcome in Mongolian Hospitals. APJHM 2025.<br>7. Aldana P, et.al. Application of the 6 pillars of sustainable global surgical partnerships by the Neurosurgery Outreach Foundation with lower-middle-income countries in Asia. Neurosurg Focus. 2025 Mar 1;58(3)<br>8. Trapane P, Baasanjav M, Purevsuren J. TWIST related disorders in two Mongolian adolescents: case reports and review of the literature (abstract P390). Presented at the 2025 ACMG Annual Clinical Genetics Meeting, March 18 – 22, 2025, Los Angeles, CA. | |
| 8.4 | БСТ-3.2.4. Зайн сургалтыг хөгжүүлнэ | - | Шинээр боловсруулсан зайн сургалтын модулийн тоо | 4 | 5 | • **Зайн сургалт- 4**<br>1. Эмэгтэйчүүдийн үргүйдлийн тархалт, сэргээн засах эмчилгээ сэдэвт 1кр-ийн сургалтын хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн дагуу | 80% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025.05.28-нд Цахим хэлбэрээр зохион байгуулсан сургалтад нийт-70 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>2. ЭМЯ-аас санаачлан хэрэгжүүлсэн “ЭХ-ХҮҮХДИЙН САР”-ын хүрээнд ЭХЭМҮТ-өөс цахим сургалтыг шат дараатайгаар зохион байгуулсан. Уг сарын хүрээнд нийт 4 удаагийн цахим сургалт “Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж”, “Хэвлийн цочмог өвдөлт, ялган оношилгоо”, “Нярайн шарлалтын оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо”, “Мэс засал тойрны сувилахуй” сэдвийн хүрээнд зохион байгуулсан бөгөөд сургалтад 21 аймаг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, Дүүргийн эмнэлэг, өрхийн эмнэлэг, хувийн хэвшилийн эмнэлгийн нийт 401 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдав.<br>3. “Инсулинээс хамаарах чихрийн шижинтэй хүүхдийн сахарыг тасралтгүй хянах нь” сэдэвт 0,5 кр-ийн сургалтын хөтөлбөр боловсруулж батлуусан. 2025.11.07-нд Цахим хэлбэрээр буюу ZOOM-ээр зохион байгуулагдсан. Сургалтад нийт-170 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>4. Судалгааны арга зүйн цахим хичээлийн 1 модуль боловсруулсан.<br>• МООДЛЕ цахим сургалтын системийг хөгжүүлэх ажлын хүрээнд ЭХЭМҮТ болон Процесс интеллиженс ХХК хамтран ажиллах гэрээг 2025 оны 08 сарын 11-нд байгуулсан. Уг гэрээний хүрээнд НЭМСА-ны 2 мэргэжилтэн, ИТА-ны 1 мэргэжилтэн 09-р сарын 12-ны өдөр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чиглүүлэх сургалтад хамрагдсан. Ээлжит сургалтыг 11-р сарын 07-нд НЭМСА-ны мэргэжилтнүүд, ИТА-ны 1 мэргэжилтэн нарт зохион байгуулсан. | |
| 8.5 | БСТ-3.2.5. Эрүү нүүрний нөхөн сэргээх гоо сайхны мэс заслын мэргэжил олгох ба дээшлүүлэх сургалтыг бусад эмнэлгүүдтэй хамтран эрхлэн явуулдаг болно | - | Сургалтад хамрагдсан эмч мэргэжилтний тоо | 3 | 3 | • "Хүүхдийн эрүү нүүрний мэс засал судлал" мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг ЭМХТ-өөр батлуулж, сургалтын эрх авах материалыг ЭМС-ын А/337 тоот тушаалын 17 шалгуурын дагуу бүрдүүлж, ЭМХТ-д хүлээлгэж өгсөн.<br>• Одоо хүүхдийн эрүү нүүрний мэс заслын олгох курсэд **2 эмч суралцаж** байна. | 100% |
| 8.6 | 5.2.1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлнэ | - | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | • ЭХЭМҮТ-ийн авлигаас урьдчилан сэргийлэх, авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр хийх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 23-нд төвийн захирлаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн дагуу ХАСХОМ мэдүүлэх 52 албан тушаалтны мэдүүлгийг хуулийн хугацаанд нь /2025.02.15/ нэгтгэн баталгаажуулж, ЭМЯ-ны Эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн, Шинээр томилогдсон 14 албан тушаалтны ХАСУМ, ХАСХОМ мэдүүлгийг хуулийн хугацаанд нь мэдүүлсэн.<br>• Авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газрын веб хуудсыг төвийн www.ehemut.mn веб хуудастай холбон ажиллаж байна.<br>• Төвийн www.ehemut.mn веб хуудсанд Авлигын эсрэг хамтдаа булан нээж, ЭХЭМҮТ-ийн авлигаас урьдчилан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэргийлэх, авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр хийх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, АТГ-аас бэлтгэсэн Авлигын эсрэг нэгдье шторк, инфогрфик, зураг хуудас сурталчигааг байршуулан олон нийтэд хүргэж байна.<br>• Төвийн ЭБАТ 2025.01.06, 2025.05.13, 2025.10.15-нд АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс зохион байгуулсан Авлигын онлайн сургалтанд Төвийн ЭБАТ болон ХАСХОМ бөглөх 52 албан тушаалтан, шинээр томилогдсон 14 албан тушаалтан хамрагдсан.<br>• 2025.09.26-нд Авилгын эсрэг хамтдаа нэгдье видео контент бэлтгэн www.ehemut.mn веб хуудас болон Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв пейж хуудсанд байршуулсан. Тус контент 3100 хүнд хүрсэн байна.<br><br><br><br> | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • 2025.09.23-ны өдөр Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтэн , ажил нарт “Авилга, ашиг сонирхлын зөрчил” сэдвээр сургалт зохион байгуулсан. Уг сургалтанд 100 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон<br>2025.09.23-нд ЭХЭМҮТ-ийн Ёс зүйн  салбар хороо ЭМЯ-ны Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороотой хамтран "Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" сургалт зохион байгуулсан<br>• ЭМЯ-ны ЁЗХХ-ны дарга АУ-ны доктор дэд профессор Д.Оюунбилэг, Иргэдийн өргөдөл гомдол хянан шийдвэрлэх дэд зөвлөлийн дарга Ш.Оюунчимэг, ЁЗХХ-ны гишүүн АШУ-ны доктор профессор Б.Саранцэцэг багш нар ёс зүйн сургалтыг удирдан орж, сургалтанд ЭХЭМҮТ-ийн удирдлагын баг, тасгийн эрхлэгч болон ахлах сувилагч нарын 110 гаруй ажилтан хамрагдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>• Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” самбар, хүн олноор цуглардаг НҮЗП, ХЗП, ЯТТ-уудын мэдээллийн самбарт Авлигын зурагт хуудас брошур байршуулсан.<br>• Монгол улсын “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, 2015 оны “Шилэн дансны тухай” хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн төвийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.<br>• Төвийн ЭБАТ-наас Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хагас бүтэн жилээр нэгтгэн шилэн дансанд байршуулах зөвлөмж Санхүү бүртгэлийн алба, Хүний нөөцийн алба, Тендерийн хорооны дарга нарт өгч ажилласан.<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн дагуу 8, 9 дүгээр зүйлд заасны дагуу ЭХЭМҮТ-ийн Тендерийн хороо байгуулах тухай 2025 оны А/05, А/10, А/11, А/12, А/13, А/14 тоот тушаал, тендерийн хорооны гишүүдийн ашиг сонирхлын зөрчийн мэдэгдлийг хуулийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаанд нь шилэн дансанд байршуулсан. | |
| 8.7 | 5.2.2. Төвийн пейж хуудас, вебсайтыг хөгжүүлж, тасралтгүй үйл ажиллагааг хангана | - | Мэдээлэл, зөвлөмж, хандалтын тоо | 78400 | 94080 | • Байгууллагын гадаад, дотоод вэб хуудсанд ТСА-наас хийсэн цахим хурлын мэдээлэл, зөвлөмж, сэрэмжлүүлэг тогтмол байршуулж хэвшсэн. Нийт 2,0 гаруй хүнд мэдээлэл хүрсэн байна.<br>• Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь www.ehemut.mn цахим хуудас, **“Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв**” пэйж хуудсаар иргэдэд мэдээллийг дамжуулан хүргэж байна.<br>• Тайлант хугацаанд цахим хуудас байрлах сервертэй холбоотой гэмтлийг засварлан мэдээллийг сэргээн ажилласан.<br>• ЭХЭМҮТ-ийн албан ёсны Facebook хуудас нь 2025 оны байдлаар нийт 271 төрлийн зөвлөмж, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна. Тус нийтлэлүүд нь нийт 3,066,982 хүнд хүрсэн, 121,100 удаа бусдад хуваалцсан, мөн 2,836,286 хүнд таалагдсан.<br>• Мөн ЭХЭМҮТ-ийн албан ёсны пейж хуудас нь **86,000 дагагчтай болсон** байна. | 91% |
| **Зорилт – 9. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлж, эрүүл мэндийн ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулна.** | | | | | | | |
| 9.1 | БСТ-4.1.1. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг тооцон, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг нэмэгдүүлнэ. | 21,9 тэрбум төгрөг | Төсөв (тэрбум төгрөг) | 53.0 | 56.5 | • 2025 он 01-09 дүгээр сарын байдлаар ЭМДЕГ-т тусламж үйлчилгээний 11 төрлөөр 288,723 хүний 48,506,421,900 төгрөгийн нэхэмжлэл илгээсэн илгээсэн нь 2024 оны мөн үеэс 18.5% (5839 хүний 7,604,545.1 мян.төг)-иар илүү байна. Хянагдсан гүйцэтгэл (олгох 01-09 сар)-45,752,481,928 төгрөг байна.<br>• 2025 оны 01-09 дүгээр сард 282,593 хүний 46,077,409.2 төгрөг олгохоор хянагдсан нь 2024 оны 01-09 сараас | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 8,581,073.9 мянган төгрөг 22.8%-иар өссөн байна. | |
| 9.2 | БСТ-4.1.2. ЭМД-аас санхүүжиж байгаа тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна | - | Нэмэгдүүлсэн оношийн тоо | 3 | 4 | • ЭМДҮЗ-ийн 04-р тогтоолоор нэр төрөл нэмэгдсэн. Мөн 3 дугаар улиралд ЭМДЕГ-ийн сонгон шалгаруулалтад орох бэлтгэл ажлыг хангагдсан.<br>• Сонгон шалгаруулалтаар ОХБ нэмүүлэх шалгуурыг хангаж, оролцоно. Мөн цаг үеийн шинжтэй Бөөр шилжүүлэн суулгах, Өвдөгний болон бусад үений артроз М17, үйлдлийн код 81.54 (баруун дунд чөмөгний хортой хавдрыг ясны хамт тайрах, баруун өвдөгний үеэнд имплант суулгах, эрхтэн хадгалах) ОХБ-үүдээр түр нээлгэн санхүүжилтийг нэхэмжилсэн.<br>• 2025 оны 11 дүгээр сарын 04-нд Өдрийн эмийн эмчилгээг түр нээлгэх хүсэлтийг ЭМДЕГ-т албан бичгээр илгээг шийдвэрлүүлээд байна. | 100% |
| 9.3 | БСТ-4.1.3. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг гүйцэтгэлийн үнэлгээгээр үнэлж урамшуулна. | 2,0 тэрбум.төг | Зарцуулсан санхүүжилт (тэрбум төгрөг) | 2.5 | 3.0 | • Тасгийн эрхлэгч албадын дарга нарын ажлын гүйцэтгэлийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг захирлын **2025 оны А/39 тоот** тушаалаар батлуулан үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна.<br>• Тайлант хугацаанд 2025 оны ажлын гүйцэтгэл, үр дүнгийн урамшуулалд I улиралд 946 ажилтан **733.710.824** төгрөг, II улиралд 913 ажилтан **62764876977** төгрөг, III улиралд 916 ажилтан **597.759.476** төгрөг тус тус олгосон байна. | 90% |
| 9.4 | БСТ-4.2.1. Хүний нөөцийг хөгжүүлэх ойрын ба дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийг байгууллагын эрэлт хэрэгцээтэй уялдуулан | - | Хэрэгжилтийн хувь | 90% | 90% | • Хүний нөөцийг хөгжлийн хөтөлбөрийг 2023-2026 оны байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан **9 зорилтын хүрээнд 43 ажил үйлчилгээг** төлөвлөн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн **Хүний нөөцийн хөгжлийн хөтбөлбөрийн 2025 оны хэрэгжилт** | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 5 жилээр гаргаж хэрэгжүүлнэ. | | | | | **90,6%. Хийгдээгүй 4 ажил үйлчилгээ байна.**<br>• Хүний нөөцийн хэрэгцээний төлөвлөлтийг насны, стратеги, хөгжлийн төлөвлөгөөний судалгаагаар 2025-2030 он хүртэл төлөвлөн, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж байна. Үүнд:<br>• Насны судалгаагаар<br>✓ 2026 онд 42 /10 их эмч, 17 сувилагч, 2 эх баригч, 13 бусад/ тус тус хэрэгцээтэй байна.<br>• Стратеги, хөгжлийн төлөвлөгөөний судалгаагаар:<br>✓ Бэхжүүлэх тусламж үйлчилгээ:<br>✓ Хүүхдийн цусны эмгэг хавдрын оношилгоо, эмчилгээ; Хүүхдийн зүрхний ангиограф;<br>✓ Теле зөвлөгөө теле эмчилгээ<br>✓ Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал<br>✓ Үргүйдэл эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн чиглэл<br>✓ Охидын тусламж<br>✓ Эмчилгээ оношлогоонд хиймэл оюун ухаан ашиглах<br>✓ Статистик бүртгэлийн цахимжуулах байдал<br>✓ Ургийн мэс засал/ ургийн эмчилгээ<br>✓ Умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэг<br>• Хөгжүүлэх боломжтой тусламж үйлчилээ:<br>✓ Хүүхдэд элэг шилжүүлэн суулгах;<br>✓ Хүүхдэд бөөр шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ<br>✓ Төрсний дараах сэтгэл засал<br>✓ Эмчилгээ оношлогоонд хиймэл оюун ухаан ашиглахыг өргөжүүлэх<br>✓ Жирэмслэхээс өмнөх хяналт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Үргүйдлийн оношлогоо эмчилгээний нэгж<br>✓ Жирэмсний эрт илрүүлэгт НИПТ шинжилгээ ашиглах<br>✓ Нөхөн үржихүйн эрхтэний гаж хөгжил нөхөн сэргээх мэс засал<br>✓ Робот мэс засал<br>✓ Ургийн мэс засал болон эмийн эмчилгээ<br>✓ Дурангийн мэс засал<br>✓ Үргүйдэл, эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ<br>• Хөгжүүлэх шаардлагатай тусламж үйлчилгээ:<br>✓ Хүүхдэд цусны үүдэл эс болон ясны чөмөг шилжүүлэн суулгах;<br>✓ Хүүхдийн мэдрэлийн мэс засал;<br>✓ Хүүхдийн мэдрэл, сэргээн засах, нярайн тусламж үйлчилгээ;<br>✓ ЭНЭҮТ, СХДНЭ-т хүүхдийн яаралтай мэс заслын тусламжийг хөгжүүлэх<br>✓ Судсан доторх оношилгоо, эмчилгээ<br>✓ Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхтэн /өндгөвч, умай/ шилжүүлэн суулгах<br>✓ Ихсийн патогистологич бэлдэх<br>• Эдгээр тусламж үйлчилгээний дагуу хүний нөөцийн төлөвлөлтийг 5 жилээр хийж эмч, мэргэжилтэн бэлтгэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.<br>✓ 2025 оны байдлаар төрөлжсөн мэргэшлээр<br>✓ Эх ураг судлал 1<br>✓ Эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл 1<br>✓ Зүрх судлал 1<br>✓ Хүүхдийн дүрс оношилгоо 1<br>✓ Хүзүү толгойн мэс засал<br>✓ Хүүхдийн эрчимт эмчилгээ 2 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Хүүхдийн сувилахуй 4<br>✓ Нярайн сувилахуй 3<br>✓ Гемодиализ 2<br>• Мэргэжил дээшлүүлэх<br>✓ Эх барих эмэгтэйчүүдийн хэт авиан оношилгоо 1<br>✓ Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал 1<br>✓ Эмэгтэйчүүдийн мэс засал 1<br>✓ Эх барих эрчимт эмчилгээ 1<br>✓ Зүрхний хэм судал 1 тус тус суралцаж байна.<br>• Цаашид<br>✓ Мэдрэлийн мэс заслын эмч<br>✓ Эрүү нүүрний гажиг заслын эмч<br>✓ Ургийн мэс засалч<br>✓ Хөхний эмч<br>✓ Хими эмчилгээний эмч<br>✓ БЗДХ-ний эмч<br>✓ Эмбриологич<br>✓ Ангиографийн техникч<br>✓ Interventional angiographist<br>✓ Interventional radiologist<br>✓ Хоол зүйч эмч бэлдэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.<br>• 2025 онд **мэргэжил дээшлүүлэх сургалтад** тус төвөөс **28** эмч, сувилагч, эх баригч нар 8 чиглэлээр суралцсан байна. Төлбөрийн хэлбэрийг авч үзвэл: төрийн сан 8, хувь-8, байгууллага 12<br>• 2025 онд **дотоод сургалтыг** 21 удаа зохион байгуулж нийт **1102 албан хаагч** хамрагдсан байна.<br>• 2025 оны 11 сарын байдлаар **гадаад улсад** сургалт, хуралд **58** эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаад байна.<br>• Ажилчдын сэтгэл ханамжийн судалгааг 2025 онд 2 удаа зохион байгууллаа. **Нийт 642 ажилтан буюу нийт ажилчдын 61%** нь судалгаанд хамрагдсан. Сэтгэл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ханамжийн судалгаагаар **ерөнхий сэтгэл ханамж 85,2% нь сайн** буюу дунджаас дээш үнэлгээтэй байна. 2024 оны судалгаатай харьцуулвал ажилчдын **ерөнхий сэтгэл ханамж 13%-аар сайжирсан** байна. | |
| 9.5 | БСТ-4.2.2. Эмч ажилчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. | 348,3 сая.төг | Хэрэгжилтийн хувь | 90% | 90% | • ЭХЭМҮТ-ийн Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 4 зорилт, 22 ажил бүхий төлөвлөгөө боловсруулан захирлаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>• Цалин нэмэх боломжуудыг судлан 2025.01.01-нээс МЗЭЭТ, ХЭЭТ, НЭЭТ, ГНДНЭЭТ, ЭБЭЭ ЭЭТ-ийн **56 сувилагчид 20%** эрчимтийн нөхцлийн нэмэгдэл, **ХЭ СЗЭТ-ийн эмч, сувилагч, хөдөлгөөн засалч** нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах нөхцлийн нэмэгдэл **20%,** Санхүү бүртгэлийн албаны **6 нягтлан бодогчид хариуцлагатны 15%**, Сувилахуйн албаны **4 арга зүйчид хариуцлагатны 20% нэмэгдэл**, ТААТ-ийн **20 харуулыг** лифтний аюулгүй ажиллагааны сургалтанд суралцуулан, лифтний аюулгүй байдлыг хариуцуулж, **хариуцлагын нэмэгдэл 50.000** төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.<br>• 2025 оны 11 сарын байдлаар төрийн дээд одон медаль, Засгийн газрын шагналаар шагнагдсан ажилтан албан хаагчдад нийт **29.278.978** төгрөгний урамшуулал олгосон байна<br>• 2025 оны 11 сарын байдлаар **ар гэрийн гачигдал** тохиолдсон ажилтанд албан хаагчдад нийт **4.750.000** төгрөгний тэтгэмж олгосон байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • 2025 оны 11 сарын байдлаар **140 ажилтанд цалинтай, 53 ажилтанд цалингүй чөлөө т**ус тус олгосон байна.<br>• 2025 оны 11 арын байдлаар өндөр насны тэтгэвэрт гарсан 22 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд **614.139.465** төгрөгийн төрийн албанд ажилласан хугацааны мөнгөн тэтгэмж олгосон.<br>• Сар шинийн баярыг тохиолдуулан гэрээр **5 ахмадад** хүндэтгэл үзүүлэн **1 сая** төгрөгний тусламж үзүүлсэн.<br>• Мөн төвийн **500 гаруй ахмадуудыг** хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг өгсөн.**10,0 сая** төгрөг зарцуулсан.<br>• Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан **“1000 хүүхдийн баяр”** арга хэмжээг зохион байгуулж, ажилтны **10 хүүхдийг Найрамдал зусланд амрах эрхийн бичгээр** шагнаж, **0-12 насны 900 гаруй хүүдэд гарын бэлэг** өгсөн.<br>• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын дагуу 2025 онд **121.752.800 төгрөгний хөдөлмөр хамгааллын хувцсаар** хангасан байна. Үүнд:<br>✓ Эмч халаад 450 ш 24.840.000 төг<br>✓ Эх баригч хослол 75 ш 7.440.000 төг<br>✓ Сувилагч хослол 425 ш 42.160.000 төг<br>✓ Үйлчлэгч хослол 180 ш 15.876.000 төг<br>✓ Жолооч хослол 5 ш 663.000 төг<br>✓ Харуул хослол 20 ш 2.644.000 төг<br>✓ Цахим хувцас 16 ш 3.523.200 төг<br>✓ Инженер техникийн ажилтны хослол 35 ш 3.857.000 төг<br>✓ Дэмжих үйлчилгээний ажилтны хослол 152 ш 15.078.400 төг<br>✓ Тогооч хослол 15 ш 2.148.000 төг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • 2025 оны 01 дүгээр сараас долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гаригуудад 16:00-18:00 цагийн хооронд ЭХЭМҮТ-ийн ажилчдад ЭБЭЭ-ийн НҮЗП-ийн дотрын эмч хоол боловсруулах эрхтний үзлэг оношилгоо хийж, зөвлөгөө өгч байна.<br>• 2025 оны 11 сарын байдлаар 203 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажилтан үзлэгт хамрагдаж, зүрхний цахилгаан бичлэг, эхо, цээж гэрэл харуулан зөвлөгөө өгч ажилласан байна. Үүнд:<br>✓ Амьсгалын гаралтай халдварууд<br>✓ Зүрх судасны эмгэг, АД ихсэх эмгэг<br>✓ Бөөр шээсний замын үрэвсэл<br>✓ Мэдрэлийн гаралтай эмгэг илүү оношлогдсон байна.<br>• Эрүүл мэндийн хугацаат үзлэгийн хүрээнд 2025 оны эхний хагас жилд АШУИС-ийн Молекул биологийн лабораторитай хамтран бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрыг илрүүлэх (өтгөнд далд цус илрүүлэх) шинжилгээнд 250 гаруй эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>• Ажилчдын эрүүл мэндийн хугацаат үзлгийн 2025.10.27-2025.11.28-ны өдрүүдэд зохион байгуулж ажиллаж байна.<br>• 2025 оны 11 сарын байдлаар **ЭХЭМҮТ-ийн 15 ажилтан, 19 ажилтны хүүхдэд 40 удаагийн ганцаарчилсан сэтгэлзүйн зөвлөгөө** өгсөн. Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ нь СВТ /танин мэдэхүй, зан үйлийн сэтгэл засал/-д тулгуурлан явагдсан. Одоогоор 9 ажилтанд сэтгэл зүйн эерэг өөрчлөлт гарч /тулгамдсан асуудлаа даван туулах чадвар дээшилсэн/, 2 нь тодорхойгүй /урт хугацааны/ сэтгэл зүйн тусламж | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээ шаардлагатай бөгөөд тусламж үйлчилгээ үргэлжилж байна.<br>• ХААН банкны Баруун хүрээ тооцооны төв, Хас банкны Тумбааш тооцооны төв, Голомт банкны Москва салбар, ХХБ-ны салбартай хамтран ажиллах гэрээ байгуулан, байгууллагын ажилтан, албан хаагч нарт цалинг картаар олгох, картын бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх, цалингийн, хэрэглээний, 8%-ийн орон сууцны зээлд хөнгөлөлттэй /урт хугацааны, бага хүү, зээлийн хэмжээг нэмэгдүүлэх/ нөхцлөөр хамрагдах боломжийг бүрдүүлэн ажиллаж, Хаан банкнаас 30 хүртэлх сарын хугацаатай 1.7-1.9%-ийн хүүтэй, Хас банкнаас 30 сарын хугацаатай 1.7-1.9%-ийн хүүтэй, Голомт банкнаас 30 сарын хугацаатай 1.8-2.3%, ХХБ-аас 1.1-1.8%-ийн хүүтэй цалингийн зээл авах боломжийг бүрдүүлсэн.<br>2020 оноос хойш ХХБ-ны ипотекийн зээлд 92 ажилтан хамрагдаж 8,8 тэрбум, цалингийн зээлд 426 ажилтан хамрагдаж 3,9 тэрбум төгрөгийн зээлд хамрагдсан байна.<br>Голомт банкины цалингийн зээлд 15 ажилтан 261.2 сая төгрөг, орон сууцны зээлд 2 ажилтан хамрагдаж 180 сая төгрөгийн зээл авсан байна.<br>2025 оны 01 дүгээр сарын 01-нээс **ээлжинд хонож ажиллаж байгаа бүх эмч, сувилагч ажилтан нарыг хоолоор хангаж байгаа** нь ажилтнуудын талархлыг хүлээж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9.6 | БСТ-4.3.1. Хүүхдийн зөвлөх поликлиникийн стандартад нийцсэн өргөтгөл байр барина | 21,5 тэрбум төгрөг (Улсын төсөв) | Барилгын ажлын явцын хувь | 80% | 100% | • 2022 оны 11-р сарын 25-ны өдрөөс эхэлсэн “Хүүхдийн зөвлөх поликлиникийн барилга”-г 2025 оны 05 дугаар сарын 31-нд улсын комисс хүлээн авч, 9-р сарын 1-ний өдрөөс үйл ажиллагаагаа эхлүүлсэн.<br>• Тус поликлиник нь 6 давхар бүхий нийт 164 өрөөтэй, 8329 $м^2$ талбайд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх таатай орчин бүрдүүлэх зорилгоор тасаг нэгж албадуудын санаачлагаар хандивын аян өрнүүлж тохижуулсан.<br>• Барилгын 5-р давхарт байрлах дурангийн хэсэг, вакум мэс заслын 5 өрөө, 1-р давхарт байрлах өсвөр үеийн клиник бүрэн ашиглалтад ороогүй. Нэмэлт санхүүжилт шийдэгдэхийг хүлээж байна. | 90% |
| 9.7 | БСТ-4.3.3. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тасаг нэгжүүдэд хуваарийн дагуу их засвар хийнэ | 9,9 тэрбум төгрөг, (Улсын төсөв) | Засварын ажлын явцын хувь | 80% | 100% | • ЭМС-ын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/19 тоот тушаалын 1-р хавсралтаар ЭХЭМҮТ-ийн барилгын их засварын 2025-2026 онд хэрэгжих ажлын жагсаалтыг баталсан.<br>• **Нийт төсөвт өртөг**: **24,861.3 төгрөг.** Үүнээс 2025 онд **9,944.6** төгрөгийн санхүүжилт хийгдэнэ.<br>• 2025 онд 5 багц ажил хэрэгжинэ. Үүнд:<br>1. 6-1 блокын их засвар үргэлжилж байна.<br>2. 6-3-1, 2 блокоос 6-3-2 дуусаж техникийн комисс ажиллан ашиглалтад хүлээн авсан.<br>3. ЭБЭЭ-ийн Гадна хүчитгэлийн гадна ариутгах татуургын шугам зөөх ажил дууссан. Тулц хана угсрах ажил үргэлжилж байна.<br>4. ЭБЭЭ-ийн барилгын их засварын нэмэлт ажил (мэс заслын 1 өрөө, эмчилгээний хоол судлалын тасгийн халаалт, хэрэглээний шугам сүлжээ, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цонх солих ажлууд) бүрэн хийгдэж дууссан.<br>5. ХЭ-ийн 6-1, 6-2, 6-3-1, 6-3-2, 6-4 зэрэг барилгуудын фасад хийгдэхээс 6-4 дууссан, 6-2 болон 6-3-1 хийгдэж байна.<br>• НҮБ-н Хүн амын сангийн санхүүжилтээр засварлагдаж байгаа “Хүүхдийн зүрхний нээлттэй мэс засал”-н хагалгааны өрөөний засварын ажил бүрэн дууссан. Улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан. | |
| 9.8 | Цэцэрлэгийн барилга (150 ор) барина | 3,5 тэрбум төгрөг (Улсын төсөв) | Барилгын ажлын явцын хувь | 80% | 100% | • Цэцэрлэгийн барилгын дотор заслын ажлын үргэлжилж байна. | 100% |
| 9.9 | БСТ-4.3.4. Багаж, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний хэсэг байгуулна | - | Байгуулагдсан засвар, үйлчилгээний хэсэг | 1 | 1 | • Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба нь эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн барилгад шилжин тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ үзүүлж байна.<br>• Нийт 4 өрөөтэй. Үүнд:<br>1. Тасгийн эрхлэгчийн өрөө 12мкв<br>2. Инженерүүдийн өрөө 20мкв<br>3. Хүчилтөрөгчийн станцын цэнэглэгч нарын өрөө 14мкв<br>4. Электроник засварын өрөө 12мкв тус тус өрөөтэй болсон.<br>• Электроник засварын өрөө нь тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийх багаж хэрэгсэл, тест анализаторууд, хүчилтөрөгчийн баллон гэх мэт шаардлагатай багаж хэрэгслээр хангагдсан.<br> | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Зураг 1. Электроник засварын өрөө | |
| 9.10 | БСТ-4.3.5. Эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалах агуулахыг стандартын шаардлагад нийцүүлнэ | 14,0 сая.төг | Стандартын шаардлага хангасан агуулах | 4 | 5 | • 2025 онд шинээр 1 нөөцийн агуулахтай болж,нийт 5 агуулахтай болсон. Эм, эмнэлгийн хэрэгслийн дэд агуулахын хэсгийг тохижуулахад 14,050,000 төгрөгийг зарцуулсан. /агуулахын тавиурыг шинэчилж, урсгал засварыг хийсэн/<br>• Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг болон хүүхдийн эмнэлэгт эм олгох дэд агуулахуудыг үүсгэж үйл ажиллагаар жигдрүүлэн ажиллаж байна. | 100% |
| **Зорилт– 10. Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын үеийн бэлэн байдлыг хангана.** | | | | | | | |
| 10.1 | БСТ-5.1.1. Төвийн гамшгаас хамгаалах орон тооны бус штаб жил бүр төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлнэ | - | 3 сарын нөөц бүрдүүлэлтийн хувь | 100% | 100% | • 2025 оны 01 сарын 17-ны өдрийн төвийн захирлын А/07 тоот, 10 дугаар сарын 02-ны өдрийн А/137 тоот тушаалаар “Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн , ажил үүргийн хуваарийг шинэчлэн батлах тухай” шинэчлэн батлуулж, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.<br>• Монгол улсын “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 34 дүгээр хууль, Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”-ыг хэрэгжүүлэх, Засгийн газрын 2017оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 67 дугаар тогтоолын дагуу тус төвийн нийт ажилтан албан хаагчдад төлөвлөгөөг танилцуулж, төлөвлөгөөний дагуу 03 дугаар сарын 27-ны өдрийн 16.00 цагт гамшгийн дуут дохиоллын цугларалтыг бүх тасаг, нэгжийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. /Гамшгийн үеийн дадлага сургуулилтанд мэргэжлийн ангийн дарга, мэргэжлийн ангийн орлогч дарга, мэргэжлийн ангийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нарийн бичгийн дарга нар, нийт 224 ажилтан оролцсон/<br>• 2025 оны 10 дугаар сарын 16-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Нийслэлийн засаг даргын нэрэмжит “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг-2025” үзлэг шалгалтад бэлтгэл хангаж оролцож “Дүүрэн хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн.<br>• Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрэглэх 65 нэр төрлийн эм тариа, 29 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 9 нэр төрлийн хувийн хамгаалах хэрэгсэл, 6 нэр төрлийн ариутгал халдваргүйтгэлийн бодис, 5 нэр төрлийн оношлуурын жагсаалт гаргаж батлуулан 7 хоногийн нөөц бүрдүүлэн ажиллаж байна. | |
| 10.2 | БСТ-5.1.2. Гамшиг, нийтийг хамарсан өвчлөлийн үед шаардагдах эд материалын нөөцийг бүрдүүлж хадгалалтыг сайжруулна | | Бүрдүүлсэн нөөц (сараар) | 3 сар | 3 сар | • Эрүүл мэндийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 14 өдрийн А/211 тушаал болон 2009 оны 11 дүгээр сарын 17 өдрийн 388 тоот тушаал дагуу болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрэглэх 65 нэр төрлийн эм тариа, 29 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 9 нэр төрлийн хувийн хамгаалах хэрэгсэл, 6 нэр төрлийн ариутгал халдваргүйтгэлийн бодис, 5 нэр төрлийн оношлуурын жагсаалт гаргаж батлуулан **7-14 хоногийн нөөц** бүрдүүлэн ажиллаж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт болон хүчинтэй хугацаанд FIFO зарчмыг баримталж хяналтыг хийж, бүртгэл хөтлөн ажиллаж байна.<br>• Гамшиг, нийтийг хамарсан өвчлөлийн үед шаардагдах материалын нөөцийг бүрдүүлэх чиглэлээр шардлагатай тохиолдолд тасаг нэгжүүдээс 11 нэр төрлийн 87 ширхэг эмнэлгийн тоног | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төхөөрөмж шилжүүлэн ажиллах зураглал гарган бэлтгэсэн.<br>• Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай багаж хэрэгсэл болох гал унтраагуур-22ш , Галын аюулгүй ажиллагааны самбар-42 ш, Гал унтраагуур тогтоогч-35ш, Галын бүтээлэг-11ш, хувин-7, хүрз-7, цохиур-7, элсний хайрцаг-1ш, галын хорны шалгах хуудас-70ш, тамхи татах хориотой тэмдэг-10ш нийт 3,856,400 төгрөгийн өртөгтэй багаж хэрэгслийг тасаг, нэгжүүдэд хүлээлгэж өгсөн.<br>• Цахилгааны аюулгүй байдал, газардуулга, нөөц үүсгэвэр, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажилласан. | |
| **Зорилт – 11. Сургалтыг тасралтгүй зохион байгуулж, хүний нөөцийг чадавхжуулна.** | | | | | | | |
| 11.1 | БСТ-3.1.1. Өндөр хөгжилтэй орны эмнэлэг, судалгааны төвүүдтэй хамтарсан багийн сургалтын "Хосолсон" хөтөлбөрийг эхлүүлнэ. | - | Хөтөлбөр, гэрээний тоо | 1 | 2 | Хөтөлбөр, гэрээний тоо -5<br>1. БНСУ-ын Самсунг эмнэлэгтэй хийсэн хамтын ажиллагааны гэрээг шинэчлэн 2025.04.10-нд хийсэн.<br>2. БНХАУ-ын Рэнжи Эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулав.<br>3. БНХАУ-ын Фудан эмнэлэгтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.<br>4. 2025.08 сард БНСУ-ын Илсан Эмнэлэгтэй хийсэн хамтын ажилагааны санамж бичиг байгуулав.<br>5. 2025.08 сард Тайваны Юн Рун эмэгтэйчүүд, хүүхдийн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулав. | 100% |
| 11.2 | БСТ-3.1.2. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, хамтарсан сургалт зохион байгуулна. | - | Хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо | 2 | 3 | **Хамтарсан сургалт-3**<br>• 2025 оны 5-р сарын 30-ны өдөр “Neurosurgery Outreach Foundation“ сангийн хүүхдийн мэдрэлийн болон мэс заслын эмч нар, 21 аймаг, 9 дүүргийн нийт 110 эмчид хүүхдийн мэдрэлийн мэс заслын чиглэлээр сургалт зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • "Монгол улсад хүүхдийн дүрс оношилгооны чадавхийг сайжруулах үндэсний сургалт" сэдэвт хөтөлбөр боловсруулж ЭМХТ-өөр батлуулсан. Уг сургалт 09 дүгээр сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулагдаж нийт 173 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>• 2025 оны 09 дүгээр сарын 25-28 өдрүүдэд зохион байгуулсан "Эх хүүхдийн эрүүл мэнд – Эх орны эрхэм баялаг" эрдэм шинжилгээний хуралд дараах илтгэлүүд тавигдав.<br>1. **Эмнэлзүйн генетикч Памела Трапань** "Мэдрэлийн гаралтай генетикийн эмгэгүүд"<br>2. **Хүүхдийн хавдрын эмч Эрик Сандлер** "Хүүхдийн хорт хавдрын шинэ эмчилгээний аргууд"<br>3. **Хүүхдийн гастроэнтерологич Кристл Ферейра Мартинез "**Хүүхдийн гэдэсний үрэвсэлт өвчнүүдийн менежмент**"**<br>4. **Хүүхдийн сэргээн засах эмч Лаура Хаборт Портер "**Хүүхдийн гэмтлийн сэргээн засах эмчилгээ | |
| 11.3 | БСТ-3.1.3; 3.2.2. Эмч, эмнэлгийн ажилчдын хэрэгцээнд суурилсан сургалтуудыг төлөвлөж, мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулна. | 361,0 сая.төг (НҮБ-ХАС, ДЭМБ, ЭМДС, Улсын төсөв) | Гадаадад сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | 15 | 20 | • 2025 онд **38 эмч, эмнэлгийн мэргэжилтэн** гадаадын өндөр хөгжилтэй оронд 3-6 сарын мэргэжил дээшлүүлэх сургалт, хурал зөвлөгөөнд хамрагдсан байна.<br>1. БНХАУ-ны Шанхай хотын Фуданы их сургуульд зүрхний мэс заслын ахисан түвшний сургалтад 8 эмч, эмнэлгийн мэргэжилтэн 2025.04.02-ноос 3-6 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж байна.<br>2. БНСУ-ын Самсунг эмнэлгийн хамтын ажиллагааны хүрээнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Хүүхэд, нярайн зүрхний мэс заслын чиглэлээр мэргэжил дээшлүүлэх” сургалтад нярайн зүрхний мэс заслын багийн 16 эмч, эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүнтэй 2025.06.02-ноос 30-80 хоногийн хугацаатай хамрагдсан.<br>3. ХЭ СЗЭТ-ийн 1 их эмч ӨМӨЗО-ны ОУ-ын Монгол эмнэлэгт мэргэшил дээшлүүлэх 5 хоногийн сургалтад 2025 оны 04-р сарын 18-27-нд хамрагдсан.<br>4. Дани улсад зохион байгуулагдсан EATCS 2025 Зүрхний нээлттэй мэс заслын олон улсын хурал, гардан сургалтад 2025 оны 10-р сарын 08-11-ний хооронд 3 эмч оролцсон.<br>5. БНСУ-д зохион байгуулагдсан Хүүхдийн гематологи, хорт хавдрын эмчилгээний олон улсын хурал, практик сургалтад 2025 оны 11-р сарын 04-16-ны хооронд 8 эмч, эм зүйч нар оролцсон.<br>6. ОХУ-д зохион байгуулагдсан Эх нялхсын эндэгдлийг бууруулах арга зам сургалтад 2 эмч 2025 оны 10-р сарын 18-аас 11-р сарын 02-ны хооронд хамрагдсан байна.<br>• Эдгээр эмч нарт Хөдөлмөрийн дотоод журмын дагуу цалинтай чөлөө олгож, 5 жилийн тогтвортой ажиллах гэрээ байгуулсан байна.<br>• 10 эмч АНУ, БНСУ зэрэг гадаад оронд ОУ-ын хурал зөвлөгөөнд оролцсон байна. | |
| | | | Дотоод сургалтад хамрагдсан эмч, | 15 | 20 | • 2025 онд төвийн хэмжээнд нийт 21 төрлийн дотоод сургалт зохион байгуулагдсан байна. Сургалтанд нийт **1102 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд** хамрагдсан болно | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэргэжилтний тоо | | | | |
| 11.4 | БСТ-3.2.1. Хүүхэд, эх барих эмэгтэйчүүд, сувилахуйн чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулна | - | Суралцагчдын тоо | 100 | 100 | • 2025 онд 166 эмч, сувилагч, эх баригч нар төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх сургалтыг амжилттай төгссөн.<br>1. Төрөлжсөн мэргэшлээр 18 чиглэлээр **121** эмч амжилттай төгссөн.<br>2. Мэргэжил дээшлүүлэх сургалтад 9 чиглэлээр 45 мэргэжилтэн<br>• ЭХЭМҮТ-өөс төрөлжсөн мэргэшлийн сургалтад 36 эмч, сувилагч 15 чиглэлээр суралцсан байна.<br>• Мэргэжил дээшлүүлэх сургалтад төвөөс 28 эмч, сувилагч, эх баригч нар 8 чиглэлээр суралцсан байна. | 100% |
| | | | Хөтөлбөрийн тоо | 4 | 4 | • 2025 онд мэргэжил дээшлүүлэх 2 хөтөлбөр шинээр батлуулж, 4 хөтөлбөрийг сунгуулж, 6 хөтөлбөрт сургалт явуулах эрх авсан.<br>• Сувилахуйн тэнхим 2025 оны төгсөлтийн дараах сургалтыг 4 хөтөлбөрийн дагуу нярай, хүүхэд, эх барихын чиглэлээр мэргэшүүлэх, дээшлүүлэх сургалтанд хөдөө орон нутгийн 1, 2-р шатлалын 62 мэргэжилтний сургалтыг амжилттай зохион байгуулан явуулж байна.<br>• Мэргэшүүлэх сургалт “Хүүхдийн сувилагч”-23, “Нярайн сувилагч”-9 мэргэжилтэн суралцаж байна.<br>• Дээшлүүлэх сургалт: “Эх барихуйн”-ын дээшлүүлэхэд 18 эх баригч, хүүхэд, нярайн 10 мэргэжилтэн хамрагдаж амжилттай төгссөн. Үүнд: “Хүүхдийн сувилагч”-6, “Нярайн сувилагч”-4 сувилагч тус тус хамрагдсан. | 100% |
| 11.5 | БСТ-3.2.3. Багшлах боловсон хүчнийг | - | Сургалтад хамрагдсан багшлах | 60% | 75% | • 2025-2026 оны хичээлийн жилд багшлах бүрэлдэхүүнийг ЭХЭМҮТ-ийн захирлын 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сурган заах арга зүйн сургалтад хамруулна. | | боловсон хүчний хувь | | | А/149 тоот “Багшлах бүрэлдэхүүн томилох тухай” тушаалаар баталж, багшлах бүрэлдэхүүнээс АУ-ны доктор 13, клиникийн профессор 40, АШУ-ны магистр 3, АУ-ны магистр 60, зөвлөх зэрэгтэй эмч 30, тэргүүлэх зэрэгтэй эмч 51, ахлах зэрэгтэй эмч 36, нийт 129 багш, 43 чиглэлээр багшилж байна.<br>• Нийт багшлах бүрэлдэхүүн өмнөх жилээс 12.5%-иар өссөн ба багшлах бүрэлдэхүүний **91.2% нь эмнэлзүйн сургагч багш, сурган заах арга зүйн сургалтад хамрагдсан** нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.9%-иар өссөн үзүүлэлттэй байна. | |
| **11 зорилтын хүрээнд 110 (дэд-11), нийт 121 арга хэмжээ төлөвлөн 119-ийг 90%-ийн биелэлттэй** хэрэгжүүлсэн байна.<br>Шинээр нэвтрүүлж, нутагшуулах **3 ажил тохиолдол бүртгэгдээгүй** улмаас хийгдээгүй. | | | | | | | |

ЭХЭМҮТ-ийн ЗАХИРАЛ Ж.ОТГОНБААТАР